

ХОРЧИН-МОНГОЛ ВЕНЕРА БА ЭТҮГЭН
(Монголын Нууц Товчоог метафорын толинд харах – 3)

Ж. Лувсандорж¹

Хураангуй

Энэ өгүүлэл бол “Монголын Нууц Товчоог метафорын толинд харах” сэдэвээр зохиогчийн хийж буй судалгааны ажилын үргэжиллэл юм. Карлын Их Сургуулийн Монголын судлалын семинарын хээрийн ажилын хэсэг, Хорчин монгол нутагаас 20 – 24 мянган жилийн өмнөх Венера бурханы дүрсийг олов. Түүний балар эртэний монгол нэрийг *Этүгэн* гэж байсан байх гэж таамнаж байна. Энэ санаанд суурилан МНТ-д гардаг, нүүдэлчидийн соёл, сүжиг сэтгэлгээний түүхийг эзэлсэн **эх, этүгэн, нутаг** хэмээх үгс, тэдгээрээс төрсөн соёл түүхийн ноцтой үгс (жишээлбэл МНТ: *eke, keke, ke'eli, e'ede, e'enegče; ötökü, ötög, ötögüle'ül-*), тэдгээрийн гарал, метафор, утга соёлын талаар тайлбар өгөхийг оролдож байна.

МНТ-ны *ötökü yeke qan* - §189, *ötöküs kebtegül* - §230, *ötög uysan-u qoina* - §154, *erkin egede* - §154, *egenegče qoimar* - §165 гэх мэтийн ээдрээтэй нэлээд үг хэллэгүүдийг өөрөөр тайлбарлаж байна.

0. Оршил

Карлын их сургуулийн Монголын судлалын семинараас 2008 оны зун явуулсан хээрийн ажилын материалын дотор, европ дахины соёлд Венера гэдэг балар эртний уран цоолборын гэрэл зураг (дагалт зураг – 1. үзэмүү) онцгой анхааралыг татаж байна. Тэр гайхамшиг, Өвөрмонголын Хорчин нутагийн монгол бөө Муунохой гуайн хадгаламжинд байгаа онгодуудын дүрийн цуглуулгад² оршижээ. Муунохой бөөгийн хэлэхээр бол тэр нь *Хатан буумал, Догшин хатан* гэдэг нэртэй онгод юм гэнэ. Хорчин-монгол Венерагийн **дүр байдал нь** евроазийн олон газараас олдсон бусад Венератай (дагалт зураг – 2. үзэмүү) эгээ нэгэн адил хүйсийн бэлгэс төгөлдөр, **утга санаа нь** үр төл, охин заяаны бэлгэдэл болсон шүтээн, **цаг үе нь** хүй нэгдэлийн үеийн (одоогоос хорин дөрвөн мянган жилийн өмнөх³) дүрслэх урлагийн бүтээл аж. Венерагийн тухай эдгээр тодорхойлолтууд археологийн шинжлэх ухаанаар батлагдсан, нийтээр хүлээн зөвшөөрсөн зүйл болохоор олон юм нуршаад яах вэ.

¹ Профессор. БНЧУ-ын Карлын Их Сургууль.

² Түүний онгодын зурагуудыг үзэмүү: Zikmundova, V., 2008, p.188.

³ Венерагийн нэн шинэ олдвор 2008 онд Германы баруун өмнөд нутгийн нэг агуйгаас илэрсэн нь арслан зааны соёогоор урласан 6 см. хэмжээний дүрс аж. Судлагч нарын тогтоосноор бол тэр 35000 – 40000 жилийн өмнөх урлал юм гэнэ.

Онцлон тэмдэглүүштэй нь юу вэ гэвэл Венера бурханы адил дүр, монгол үндэстэний үүсэн бүрэлдсэн уугуул нутаг гэгддэг Их Хянганы уулсын⁴ бүс – Хорчин аймагийн суусан тал нутагт хадгалагдсан явдал болно. Олон мянганыг эзэлсэн эрхэм дээд шүтээн болохоор түүний тухай өөр бусад баримт, мэдээ, мэдээлэлийг монгол хэл соёл эрхбиш хадгалсан байж таарна гэх сувдаг сонирхол төрөгдөнөм буй-заа.

Тэмдэглэл

2008 оны 12 сарын 8-ны өдөр, Карлын их сургуулийн Монголын судлалын семинарын жижигхэн өрөөнд болсон явдал юм. Монгол, манж хэлний багш Вероника Зикмундова доктор, Хорчины бөө мөргөлийн сэдвээр ээлжит өгүүлэлээ бичээд тооцоолуурт сууж байв. Түүний дэргэд Муунохой бөөгийн олон онгодын гэрэл зураг байна. Би түүнийгсонирхон үзтэл *Хатан буумал*, *Догшин хатан* гэдэг онгодын зураг нүдэнд тусав. “Энэ Венуше байна!” гэж би дуу алдаад, эртний монголчуудын *Этүгэн эхийн* дүр, бидний өмнө дурайж байна” гэж хэлэв. Миний үг Зикмундовад таалагдсан бололтой: “энэ зурагууд уг нь танд л байж байвал таарна” гэсэн билээ.

Европ соёлын *Венера* бурханы дүрийг *Этүгэн эх* гэдэг нэртэй холбон үзэх миний бодол, 2008 оны 6 сард Брно хотын музейдхи Венера бурханыг Прагадхи Улсын музейд залж үзүүлсэнээс эхэлсэн юм. Арван нэгхэн см хэмжээтэй тэр жижигхэн бурханыг бөх бат гэгчийн том төмөр авдарт нандигнан хийж цоожлоод, цагдаа жолоочтой тусгай зориулалтын тэргэнд оруулж батлаад, цагдаагийн газарын тусгай тэрэг дагалдан хамгаалж авчираад Улсын музейд түр байрлуулсан сүртэй явдалыг Чех улсын ТВ үзүүлсэн билээ. *Венера* бурханы дүр, *Этүгэн эх* гэдэг нэрийн утга – хоёул хүйсийн бэлгэс төгөлдөрөөр холбогдсон эртний хүний нэг шүтээн (нэг нь дүр, нөгөө нь нэр) хэмээсэн таамналд би орж судлах аргыг эрэлхийлэн байтал удалгүй Хорчин-монгол Венерагийн дүр, бидэнд “өөрөө” ирсэн азтай тохиол ингэж болсон бөлгөө.

1. Венера /Venus

Европтхины гадаад үгний тольд **Venus** гэдэг латин үгэнд: “1. archeol. pravěká kultovní soška jako symbol ženství a plodnosti (podle řím. bohyně lásky a krásy Venuše 2. kniž., expr. krásná žena”⁵; **Veneris** (Венера) – “1) вдревнеримской мифологии – богиня любви и красоты; то же, что в древнегреческой мифологии *Афродита*; 2) *астр. планета*⁶, видимая как яркая утренняя или вечерняя звезда, вторая по расстоянию от Солнца планета Солнечной системы”⁷ гэсэн тайлбар байдаг.

Үгийн гарал нь эртний ромын “бурхны хайр” (venia) гэх хийсвэр ойлголтын хүнчлэлээс ирэлтэй гэх Европын орнуудын хайр дурлал, янаг амрагийн сэдэвт зураг урлагийн бүтээлүүдэд Венерагийн дүр чухал байрыг эзэлнэ.

⁴ “Хушны сложились на лесистых склонах Иньшаня и потом лишь передвинулись в монгольские степи” (Гумилев Л., Этнос в ландшафтах. Ч и П., №10, 1988, Знание, р.28). Иньшан гэдэг нь Их Хянганы өмнөд үргэлжлэл ба дорнод монголын намхан уулсын нэр юм. Ld.

⁵ ACADEMICÝ SLOVNÍK CIZÍCH SLOV, ACADEMIA PRAHA 2001, p.806

⁶ Энэ гарагийн нэрийг ардын хэлнээ *Хомхой*(greedy) од, *Ховдог*(greedy for food) эмэгэн од гэх. Хүмүүс үдэш хоолныхоо дараа ам уруул дээрхи тосыг арчилгүй гадаа гарвал тэр Ховдог эмэгэн долоодог, тэр тийм ховдог юм гэдэг. Уруул дээр гарсан юмны нэрийг бас *хамгой* гэнэ.

⁷ СЛОВАРЬ ИНОСТРАННЫХ СЛОВ, Москва, 1988, p. 99

1.2. Уран цоолборын Венера

Одоогоос 40 орчим мянган жилийн өмнө баруун европын нутаг, их мөснөөс салах цагт орчин үеийн хэв шинжит хүн (*Homo sapiens* – ухаант хүн) тэнд нүүдэллэн очсоныг хүн төрөлхтний түүхийн шинэ хуудсыг нээсэн үйл явдал болсон гэж өрнөдийн шинжлэх ухаантан бичсэн байдаг. Европ газар, мөсөн дээлээ тайлсны дараа *шинэ чулууны* гэгдэх үед эртний хүний эдийн соёлд ноцтой өөрчлөлт гарсан нь чулуу ба ясыг боловсруулах аргазүйн дэвшил болж, шавар (эд юмсыг) шатаан боловсруулах аргыг эзэмшсэнээр дүрслэх урлаг (уран зураг, уран цоолбор / скульптура) үүсэн гарсан. Тэр эрт цагийн хүмүүсийн зурсан, цоолборлосон амьтад (арслан заан, өл буга, агуйн арслан) ба хүний дүрийг гайхалтай уран бүтээсэн дурсгалууд хадгалагдан үлджээ.

Шинэ чулууны үеийн урлагийн гайхамшиг болсон дурсгалууд дотор одоогоос 25-21 мянган жилийн өмнө бүтээгдсэн эмэгтэй хүний дүр онцгой байранд байна. Тэдгээрийг *чулууны үеийн Венера* гэж нэрлэх болсон билээ. Зарим судлагчийн бодлоор бол тэд нар, эртний хүний бурхан, элэнц эх, үр төлийн бэлгэ тэмдэг гэх. Зарим нь тэднийг ан гөрөөний аз хийморийг дуудах зан үйлийг зохион байгуулагч бодот эмэгтэйн дүр гэх. Бас зарим судлагч (Вотяков А.Н) *баба-яга* (алмас эм) гэж үзсэн зүйл ч бий.

Тэр Венера эхийн дүрсийн хэлтэрхийг анх 1894 онд Францийн Брасемпуи нутгаас олж, дараа нь 1908 онд Төв Европоос (Австийн Виллендорф), 1923 онд Дорнод Европоос (Оросын Воронеж нутгийн Костенка суурин) олжээ. Баруун Европоос Сибирь хүртэлхи нутгаас олдсон нь одоо нэгэнт хэдэн зууд хүрэв гэх.

“Венера бурхадын” дүрийн нийтлэг шинж нь гэвэл ер нь хүний бие лагшины бодот төрхөөс ихээхэн хол, дүрслэлийн хэтрүүлэг төгс нь: *ташаа, гэдэс, хөх хэт том, бэлхүүс өргөн дандгар, бэлгэ ил гарсан, холийн таваг байхгүй, нүүр байхгүй юмуу эсвэл харагдахгүй. Зарим дүр гэдэсэндээ хүүхэд тээсэн, зарим нь төрж байгаа байдалтай. Хүйнэгдлийн уран цоолборчдод бүсгүй хүний нүүр царай тийм сонирхмоор юм биш байсан** гэж зарим судлаачид бичсэн байдаг. Тэгээд Венерагийн юу юугий нь харуулах тэдэнд чухал байсан бэ гэдэг асуултад эртний уран цоолбор дүр өөрөө л хариу өгч байна. Уран сайханы хэтрүүлэлийн арга хэрэглэн дүрсэлж бод байдал ба бод мэдрэмжийг саармагжуулжээ. Тэр харагдаж байгаа дүр бол хүн биш, бурхан юм. Түүний нэрийг эртний монгол хэлээр: *Эх Этүгэн* юмуу эсвэл *Ээ – Хайрхан* гэж нэрлэж байсан гэвэл бараг онох байх. Бусад олон хэлнээ ч иймэрхүү л нэртэй байсан болов уу.

2. Этүгэн

Тэр үүдхэгч эхийг “эрт цагийн хүн юу гэсэн утгатай үгээр нэрлэж байсныг хэн мэдэх аж”* гэж хүн судлалч заримууд цохон тэмдэглэсэн нь бий.

Гэвч энэ асуултын хариуг хэлнүүдийн архиваас эрвэл юм олдох бололтой. Өвөг монгол хэлний *өдөөн эхлэгч / үүдхэгч* гэсэн утгатай **edüken eki* (халх. өдөөн эхлэх) гэсэн хоршил үгийг би, эх үндэс болгож байна. Энэ хоёр үгийн анхдагч (эхийн эрхэт ёс ид дэлгэр үеийн) утга нь эхийн хүйсийн тэмдэг эрхтэний нэр байсаныг батлах эш баримт байна.

Энэ нь Венера бурханы цоолборын утга санаатай тохирч байгаа юм. Энэ хоёр үгтэй хөтөжсөн холбоо бүхий *этүгэн / өтөгөн* (газар, дэлхий, хангай), *үтэг / өтөг* (эм бэлгэ эрхтэн), *өтгөс* (ухаант хөгшид), *удган / нидуган* (эм бөө), *нутаг* (манай нутаг,

миний газар), эх, эхэс, ээл, зэрэг утга соёлын олон чухал үгийг монгол хэл хадгалж байна.

2.1. Эмүгэн гэдэг үгийн үүсэл хувьсал

Өвөг монгол хэлний Эмүгэн (*etüken/etügen* < **edü-/etü-* 'to begin, start, commence') хэмээх үгний бурханлиг утга санааны үлдэгдэлийг хадгалсан Эмүгэн гэдэг үгний тухай анх Доржи Банзаров 1846 онд «богиня Этуген с незапмятных времен⁸» (Доржи Банзаров, 1955, р. 65) гэж, 1929 онд Б.Я.Владимирцов «монгол бичигийн хэлэнд *etügen* ~ *itügen* «богиня земли, Земля (шаманский термин)», дорнот-халхын аялгуунд **Етүгүн** «Земля, земля-владычица»⁹ гэсэн хэлбэрээр байдаг» (Владимирцов Б.Я., 1989, р. 154) гэж тэмдэглэсэн юм.

Өнөөгийн монгол (халх) хэлэнд тэр үгнээс үлдсэн юм гэвэл *өтгөн* 'thick', *өтөг* 'manure, dung, humus' гэсэн хоёр үг байна. Түүний эхнийх нь *элбэг баялаг* гэсэн санаагаар, нөгөө нь *ээлтэй бууц* гэсэн санаагаар *эмүгэн* гэдэг үгтэй битүү холбогдоно.

Үгийн гарал¹⁰:

**edü-/etü-* (үгийн үндэс) + *-ke/ge* (нэр үг бүтээх юмуу эсвэл үйлдүүлэх хэвийн залгавар) + *-n* (эртний олон тоотын юмуу эсвэл нэр үг бүтээх залгавар). Энэ тодорхой бүтэцийн утга нь *edüken /etügen* > өдөгч, өдөөгч (эхлэгч, үүсгэгч).

Уугуул анхдагч утга: эм (эхийн) бэлгэ эрхтэн¹¹

Анх эхний шилжвэр утга: а) өдөгч/өдөөгч, б) эхлэгч, үүсгэгч.

Түүхийн эрин үеүдэд салаалан хөгжсөн метафор утгас: **I.** а) эх/ээж, > б) эх шүтээн, > с) газар шүтээн, газар дэлхий. **II.** удган, > бөө удганы Тэнгэр; **III.** ариун, гэгээн дээдэс, богд; **IV.** эрхэм дээд бодгали, эрхэм дээд юм: охь дээж, өргөл; **V.** өвөг дээдэс, мэдлэг туршилгатан, хүндэт ахмад.

⁸ Известный монголист Доржи Банзаров писал: «Они (монголы) начали поклоняться богине Этуген с незапмятных времен, вероятно в одно время, как стали небу приписывать качества божества. По китайским летописям, хунну и тугю приносили жертвы земле. Из записок европейских путешественников видно, что ей воздавали божеские почести монголы во времена чингисовой монархии и что они ее почитали одним из главнейших божеств.» (Доржи Банзаров, 1955, р. 65).

⁹ „монг.-писъм. *etügen* ~ *itügen* «богиня земли, Земля (шаманский термин)», *Халх, Восст.* Етүгүн «Земля, земля-владычица»“ (Владимирцов Б.Я., 1989, р. 154)

¹⁰ Энэ үгийн гаралын тухайд Б. Я. Владимирцовын бичсэн нь: „Можно думать, что монг. *ötügen* этимологически близко со словом *ötüg* «назем, место с наземом»; как *ötügen*, так и *ötüg* являются номинальными образованиями от **ötü-*, ср. монг. –писъм. *ötü-* «заводится гниль, зарождаются черви» (Владимирцов Б. Я., 2005, стр. 842). Бидний (Ld.) үзэхээр бол мо. бич. *ötü*, ха. *өтө* 'worms, maggots' ба *ötü-* ха. *өтө-* 'to develop maggots' гэсэн үгс бол эртний монг. хэлний *edü-/etü-* 'эхэлэ-, үүсгэ-' (эртний хүний бодлоор өт бол олон хорхой шавжийн эх) гэдэг язгуур үгнээс гаралтай.

¹¹ «Интересна семантическая связь *ötügen* „земля, божество земли“, а также с монгольским названием *vulva*» (үзмүү: Банзаров Д., 1955, р.269, note 82).

2.1. Соёл түүхийн тайлбар:

2.1.1. Энэ үгийн балар эртний анхдагч утга нь эм хүйсийн тэмдэг эрхтэний нэр байсан бололтой (*утэг* гэсэн үг үзмүү). Түүний шилжвэр утга нь эхлээд *төрөгч, төрөгч* эх гэсэн утгатай байсан. Дараагийн шатанд *шүтээн эх, онгод эх, бурхан эх* гэсэн утгатай болсон. Тэр үе бол Эхийн эрхэт ёсны үе байсан. Хорчин нутагаас олдсон Венера бол тэр үеийн *Этүгэн* мөн биз ээ.

2.1.2. Цаашид түүхийн эрин солигдсоор хосмол (дуализм) шүтээнт шашинуудын цаг ирэхэд эм онгодын дүрст *Этүгэн (Венера)* мартагдсан боловч, эм шүтээний утга нь *Etügen ~ Ötügen* («Земля, Земля-владычица, божество земли», Владимирцов Б. Я., 1989, р. 154) гэдэг нэрэнд уламжлагдав. Эртний *Этүгэний* (Венера) дүр, дүрслэх урлагийн дурсгалд үлдсэн нь *боогийн онгод* буюу *буумал*¹² (бөө мөргөлийг хадгалсан нутагт), *тэнгэрийн сум*¹³ (бөө мөргөл мартагдсан нутагт) нэрийг олж уламжлагдсан ажээ.

Etügen гэдэг үг *Газар* гэдэг үгтэй синоним нэр болж *Тэнгэр* гэдэг эр хүчинтэй хосмол шүтээн болсон. Түүний баримт нь дундад үеийн монгол хэлний дурсгал – Монголын нууц товчоонд а) шүтээн, б) газар, дэлхий¹⁴ гэсэн хоёр утгаар байдаг. Жишээ:

- *erketü tengiri-de nereidcū, eke etügen-e kürgežü* 'Being named by powerful Heaven, Effecting [this] by Mother Earth'¹⁵ (§113, Cleaves F.W., 1982, p. 47)
- *ündür etügen-dür* 'in a high place' (§201, Cleaves F.W., 1982, p.140)
- *dair etügen* 'the brown Earth' (§275, Cleaves F.W., 1982, p.181)

2.1.3. *Ötüken yış* Эртний түрэг хэлний дурсгал – Орхоны рун бичээснүүдэд *Ötüken* гэдэг үг тохиолддог. Түүнийг түрэг хэл аялгуунуудын хамгийн эртний толь – Махмуд Кашгарскийн толь (11-р зуун) гэдэгт «место в татарских степях» (Владимирцов Б.Я., 2005, р.844) гэх. Түрэг судлалч нарын тайлбарласанаар бол «Түрэгийн хаант улсын төв, хааны ордон оршсон, ой ихэт уулс бүхий газарын оноосон нэр» гэх. Б. Я. Владимирцов тэр үгийг «Төв Монголын нэг ойт уулын нэр» (Владимирцов Б.Я., 1989, р. 154) гэж тодорхойлсоноос гадна, монгол хэлний *etügen / ötügen* гэдэг үгтэй холбон тайлбарлаж тусгай өгүүлэл (Владимирцов Б.Я., 2005, р.844) бичив. Түрэгийн хаант улсын төв, Орхон голын хөндийд оршсон болохоор *Ötüken yış* гэгч бол Орхон голын эхэний их ойт уулсын эртний монгол нэр *Ötüken* (одоогийн нэр нь Хангай хан, Хангайн даваа) мөн бололтой. Монголын аман зохиолд «*наян нэгэн этүгүдийн эзэд* «восемьдесят один владыка Земли», *етүгүд* – plural. < *етүгүн*» (Владимирцов Б.Я., 2005, р. 842), «*Арван гурван Алтай нутаг*», «*Хорин дөрвөн Хангай нутаг*»¹⁶ гэсэн шүтээнүүдийн уг нь балар эртний *Этүгэн* Эх мөн биз.

¹² онгон/онгод, буумал-ын тухай үзмүү: Even M-D., 1992, p. 430, p. 435; Zikmundová V., 2008, p. 154, p.179;

¹³ Үзмүү: Luvсандордž Dž., Vacek J., 1990, p.144.

¹⁴ Энэ тухай Б. Я. Владимирцов: „можно сделать вывод, что *ötügen ~ etügen* у монголов обозначало «божество земли» и «земля, сама земля, рассматриваемая как божественная»; ср. замечательное выражение, встречающееся в монгольских книжках, посвященных культу огня: *gal-tengri gal-luḡa ilḡal-ügei* «нет различия между огнем и огнем-тенгрием (небожителем, гением) ~ Гением Огня» (Владимирцов Б. Я., 2005, р. 842)

¹⁵ Cleaves-ийн орчуулга, үзмүү Cleaves F.W., 1982, p. 47

¹⁶ „*Алтай хайлах*” гэдэг туульз үзмүү, Гаадамба Ш., Цэрэнсодном Д., 1978, р. 257.

Etügen гэдэг үг, түрэг хэлэнд орсон үе бол наад зах нь 6-р зуун (монгол нутаг дээр түрэгийн хаант улс тогтсон) болно. Цаг хугацааг цаашлуулан бодвол тэр үг бүүр 1-р зуунаас Хүннү улсын бүрэлдэхүүнд монгол, түрэг хэлтэн олон аймагууд холилдон оршсон үед түрэг хэлэнд орсон байх боломжтой. *Etügen* гэдэг үг, бод дүрст шүтээний утагыг нэгэнт алдаад, газар-шүтээний утгатай болсон үеийг би Манай Тоололын өмнөх үед хамааруулан үзэж байна.

2.1.4. *Отгонтэнгэр* Хангайн нурууны оргил, эртний шүтлэгт мөнх цаст уулын нэр түүний *Отгон* гэдэг үгийн гаралыг түрэг хэлний *од* (гал), монгол хэлний *хан* (эзэн) гэсэн үгсийн нийлэмж: *галын эзэн* (гал голомтыг сахигч отгон хүү)¹⁷ гэж тайлбарладаг. Энэ тайлбар, хүүхэдийн тухайд (*отгон хүү, отгон охин*) тохиромжтой байх. Харин шүтээн уулын тухайд арай тохирохгүй. «Наян найман Этүгэдийн» хамгийн өндөр буурал нь бөгөөд агуу нь *отгон хүү* биш, *эх /эцэг* байх нь эртний хүний сэтгэлгээний ёсонд тохирох биз ээ. Тэгээд «*Etüken / Ötüken + qan, Ötüken qan + Tenggeri* > Отгонтэнгэр» гэж үзэх нь итгэлтэй юм.

2.2. *edü-* язгуур үйл үгийн авианзүйн хувьсал

Өвөг монгол хэлэнд **edü-* / **etü-* гэсэн үйл үг байсан. Түүний үндсэн утга нь эхэл-, 'начинать', *үүсгэ-* 'начинать, делать почин; порождать, создавать', шилжмэл утга нь *өдө-* / *өдөө-* 'затевать; побуждать'.

Энэ язгуур үйл үгнээс одоогийн олон монгол хэл аялгуунд *өдө, өтө, үтэ, уду, оди, омо...* зэргийн олон хэлбэр бүхий олон үндэс салбарлан гарсан юм. Тэдгээрийн жишээ болгож монгол хэлний түүхэн авиан зүйн судалгааны материалаас үзүүлэе.

2.2.1. Өвөг монгол хэлний «*e + гийгүүлэгч + ii*» (**edü-* / **etü-*) цогцын авианзүйн хувьсалын замыг монгол хэлний түүхэн хэлний зүйн судлалд, авианы ухрах ижилсэл, дэвших ижилсэл, ондоошилын зүй тогтоолоор *edür* гэдэг үгийн жишээн дээр тайлбарласан нь¹⁸:

- **edür > edür* (АМо.) > *ödür / üdür* (ММо.) 'день';
- *ödür / üdür* (ММо.) > *ödör* (Kh.), *üdür* (Bur.), *ödür* (Oir.), *ödër* (Kalm. халимаг), *üder* (баоань), *odor* (шар уйгур), *udur* (дагур), *udu* (дунсян) 'день'.

2.2.2. "При помощи *e* монг.-письм. обозначался какой-то гласный, существовавший в старом монгольском языке, средний между *e* и *ö*; по всей вероятности это было нелабиализованное *ö*, т. е. *ö* произносимое с мнимой губной работой; встречался этот звук в словах, в которых он предшествовал какой-либо губной фонеме, гласной или согласной. Подтверждается это во первых тем, что в монг.-письм. *e* чередуется с *ö*, напр.: *dörben ~ derben* «четыре», *edü ~ ödü* «перо (птичье)», *sedüb ~ södüb* «задание, задача», *Baum. öwgn ~ ewgn* | монг.-письм. *ebügen* «старик»; *Baum., Захач. емгн ~ öмгн* (Араб-Ф. *ömgon*) | монг.-письм. *emegen* «старуха»; ... (Владимирцов Б. Я., 1989, р. 151).

¹⁷ „*Odxan-tengri ayula* > халх. Одохонг-тенггер «Отхон-тенгри – младший небожитель – название горы в Центральной Халхе в Хангае», *odxan* < *od-xan* «огонь-хан», так назывались младшие сыновья, наследовавшие уделы своих отцов и являвшиеся хранителями домашнего очага» (Владимирцов Б. Я., 2005, р. 843).

² Төмөртоого Д., 1992, р. 181, жишээнд орсон үгсийн (*edür* гэсэн үг) жагсаалт үзмүү.

2.3. *Edü-* язгуур үйл үгийн уугуул утгыг одоо хүртэл хадгалж байгаа үүсмэл үндэс:

- Cl.Mo. *edü-* (Kh. *odo-*) 'to begin, start, commence'¹⁹;
- Cl.Mo. *edüge-* (Kh. *odo-*) 'to instigate, provoke, incite; to lure, allure';
- Cl.Mo. *edügül-* (Kh. *odүүл-*) 'to begin, start, lay a foundation, produce, originate, devise, commit; to induce, prompt';
- Cl.Mo. *edügegči-* (Kh. *odoогч-*) 'instigator, provoker';
- Cl.Mo. *edügel* (Kh. *odoол*) 'lure, enticement; temptation';
- Cl.Mo. *edügülbüri, edügülge* (Kh. *odoолбор, odoолго*) 'origin, beginning, extraction, descent, anything produced or, erected; product, produce, yield'

2.4. *Edü-* язгуур үйл үгийн шилжмэл утгаар метафорчилагдсан соёлын үгс

2.4.1. өтөг 1.

Kh. *үтэг* (~ *үтэг, өтөг*) < Scr.Mo. *ötügü/ütügü*²⁰, *ötüg/ütüg* 'женский половой орган'²¹ (метафор утга);

Үгийн гарал: < **edüge* / **etüge* 'өдөгч/өдөөгч' < **edüge-* / **etüge-* 'побудить, возбудить' < **edü-*;

Тэмдэглэл:

Ховор хэрэглэгдэх нутагийн аялгууны үг юм. Эртний монгол хэл, эм бэлгэ эрхтэнийг *өдөгч/өдөөгч* (өдөөн дуудагч) гэсэн утгатай үгээр нэрлэж, эр бэлгэ эрхтэнийг *халдага(н)* 'penis'²² < Cl.Mo. *qalda-* (ха. *халда-*) 'to touch; to approach, come near; to attack, encroach, violate, abuse; to be infected or contaminated with'²³ гэсэн үгээр нэрлэж байсаны дурсгал болон үлджээ.²⁴

2.4.2. өтөг 2.

Kh. *өтөг* (~ *үтэг*) < Cl.Mo. *ötege/ütege*²⁵ / *ötügü, ötüge*²⁶ 'баавгай';

Үгийн гарал ба утга: дархад аялгуунд эм баавгайг *өтөг баавгай* гэж нэрлэдгийг эс тооцвол одоогийн монгол хэлэнд нэгэнт мартагджээ. Гэвч: *үтэг* < **edü-* гэж сэргээн босгож болно.

Тэмдэглэл:

Үүдхэгч-эх (бэлгэ тэмдэг нь *үтэг*) –ийг шүтэж байсан балар эртний хүмүүсийн сэтгэлгээний дурсгал болж монгол хэлний "архивт"²⁷ үлдсэн үг

¹⁹ Жишээнд авсан үгсийн англи орчуулгыг үз: Lessing D., p.294-295.

²⁰ „*emegtei kümün-ü belge erketen-ü hüdügülig nereyidel*“ (Norjin, C., 1999, p. 677)

²¹ БАМРС., 2001, III, p. 428.

²² Lessing D., p.919

²³ Lessing D., p.918

²⁴ Монголын нэрт хэл шинжлэлтэн Б. Ринчен академич багштан, нэг лекц дээрээ энэ хоёр үгийн гаралыг тайлбарлаад "өдөөн дуудагч юм нь байгаа хойно, халдан ордог юм нь байлгүй яахав даа!" гээд инээж байсныг би санан дурсч байна.

²⁵ БАМРС., 2001, III, p.427.

²⁶ Цэвэл Я., 1966, p. 448.

ажээ. Баавгай, эртний хүнд, өөрийн бэлэн орон сууцыг (агуй) “зээлүүлсэн” болохоор ээж-этүгэнчилэн хүндлэгдэж эртний хүмүүсийн тотемийн нэг болжээ. Эм баавгай бол тотемизмийн ёсонд нэгэн бөл хүмүүсийн, хожим нь бүхэл аймаг хүмүүсийн эх болсон шүтээн байсан болохоор түүний бэлгэдэлийн нэрээр (өтөг/үтэг) нэрлэгджээ. Үүнийг гэрчлэх зарим баримт, монгол хэлтэний фольклорт хадгалагдсан нь:

- “Баавгай уг нь хүн байсан болохоор хүн шиг хойт хоёр хөл дээрээ явдаг, хүний хэл мэддэг. Анчин хүн, элтэй баавгай агнадаггүй. Баавгай их амархан төрдөг амьтан гэдэг. Тийм болохоор эм баавгайн саварыг хүн төрөхөд тус болно гэж анчид авдаг. Баавгай хүнтэй төстэй байдагийн бас нэг шинж нь эм баавгайн чүльч²⁸ нь эмэгтэй хүний бэлгэ эрхтэнтэй их адилхан гэдэг. Тийм болохоор тэр юмуу, эм баавгай алаад, залуу хүнийг шууд очуулдаггүй, залуу хүнээр арьсы нь өвчүүлдэггүй. Залуу хүн, эм баавгайн чүльчий нь хараад инээд алдаж, хөхөрсөөр элэг нь хөшиж үхдэг”²⁹ гэж ярьцгаадаг. Үүнийг жигмидийн³⁰ өвчин гэж хэлдэг” (Цэрэнсодном Д., 1989, р. 99 - 100)
- “Долоон Бурхан од гарахад өтөг баавгай (охин), эр баавгай хоёрын ороо уулзалт болдог” /Дархад эмэгтэй Х. Дарьсүрэнгийн яриа/(Цэрэнсодном Д., 1989, р. 214).

2.4.3. өтөг 3., өтөгс

Kh. өтөг, Cl.Mo. *ötegi* ‘old man; senior’, (Lessing F.D., 1960, p. 646);

Kh. өтөгс, Cl.Mo. *ötegiis/ötügiis* ‘seniors, elders, chieftains’

(Lessing F.D., 1960, p. 646, 647)

◇өтөг боол, Scr.Mo. *ötegi boyol* ‘наследственный раб’³¹ (БАМРС., 2001, III, р.47)

Үгийн гарал, тайлбар: *этүгэн*, метафор утга V: *Etügen + s* (олон тооны нөхцөл) = *etüges > ötügüs. Ötügüs > ötügi* ‘эртнээс алдаршсан, алдар цуу нь түгсэн бодгали’, ‘эрхэм дээдэс’, ‘сахиус’, ‘багштан’. Энэ үгийн метафор утга санааг нэвтрүүлэхэд англи хэлний *лорд* гэдэг үгийн зарим хэрэглээ зохимжтой байж болох юм.

Бичвэр (дундад үеийн монгол хэл, МНТ §189):

²⁷ „*Ötege* bear. *birayun ötege* A two years old bear. *cilayun ötege* Species of bear with with fur on the neck, hibernating in caves. *noqai ötege* Small species of bear. (Lessing D., 1960, p. 646). Үгчилбэл: *birayun ötege* – годовалый теленок-медвед, *cilayun ötege* – каменный медвед, *noqai ötege* – собачий медвед.

²⁸ со. мо. *julči/zulci* – caul enveloping the fetus of animals at birth (Lessing D., 1960, p. 1078); Энэ бичвэрт баавгайн бэлгэ эрхтэний нэрний эсрүүлэл бололтой.

²⁹ Одоогийн монгол хэлэнд „*элэг хөши*-(to split one’s sides with laughter /Lessing D., 1960, p. 492/), *элэг хата*-(to laugh a belly laugh / Leasing D., 1960, p. 309/), „*элэг хөшиж/ хатаж үхэ*“-гэсэн идиом байна. Утга нь *хэтэрхий инээ*-, *үхтэлээ инээ*-.

³⁰ Энэ үгийн утга ойлгомжгүй. Хүний нэр бололтой.

³¹ „Нүүдэлийн феодализмийн” (13-р зуун) нэр томьёо

«Wan-Qan erten-ü ötögü jeke qan hülege. Terigü in-ü abčiradqun mün bögesü taija bida»...«Tede ... ötökü jeke erten-ü Wan-Qan-i...ajuγulžu daižiγulžu ükügülbe» (Sumyabaatar B., 1990, p.456, §189,L.2., L.23)

Миний орчуулга:

Ван хан, эртний богд их хаан билээ. Толгойгий нь авчиратун, мөн бол бид тахья. ... Тэд...богд их, эртний Ван хааныг...айлгаж, зугтаалгаж үхүүлэв.

Орчуулгын жишээ:

– Орос: «Ван-хан ведь был древнего ханского рода. Пусть привезут сюда его голову. Если его действительно он, мы принесем ей жертву»... «они будто бы пугали... древлеславного великого государя Ван-хана своим возмущением довели его до смерти». (Козин С.А., 1942, p. 142)

– Чех: «Ong-chan byl dřive velkým chanem. Přineste sem jeho hlavu! Je-li to vskutku on, budeme mu obětovat!»... «Tito lidé starého a velkého Ong-chana...postrašili, pobili a do smrti vehnali. (Poucha P., 1955, p. 121,122)

– Англи: «Ong Qan was an aged , great qan of old. Fetch [ye] his head. If it truly be [his], we shall sacrifice [unto it]»... « Those people ...made the aged, great Ong Qan of old to be afraid, made [him] to revolt, and made [him] to die». (Cleaves F.W., 1982, p. 116, 117).

Ötöküs (өмгөс / өмөгс) гэдэг үгний хэрэглээний жишээ:

a) *kesigüd-ün ötöküs* (МНТ., §227, L. 21,22) – утга нь Чингис хааны *хамгаалагч отрядын хэсэгүүдийн/ бүлэгүүдийн дарга нар*

Үүнийг орос хэлээр “старейшины очередей, дежурные старейшины”(Козин С., 1942, p.170), чех хэлээр “Velitelé oddílů” (Poucha P., 1955, p. 169), англи хэлээр “Elders of the companies” (Cleaves, F.W., 1982, p.165) гэж орчуулжээ.

b) *ötöküs kebtégül: min-ü ölzeiten kebtégül min-ü ötöküs kebtégül kegedün* (МНТ., §230, L. 16)

Тайлбар тэмдэглэл:

Энэ бичвэртхи *ölzeiten, ötöküs* гэсэн хоёр үг бол сүжиглэх сэтгэлгээний бурханчилан үзэх модалтай үгс юм. Тэгэхдээ сүүлчийнх нь эхнийхээсээ өндөр зэрэгийн үнэлэлт болно! “*min-ü ölzeiten kebtégül*” гэдэг бол ха. *миний өлзийтөн* (надад өлзий ивээлээ өгсөн) *хэвтүүл* = *миний ачтан хэвтүүл* (чех: *moji blahodárný strážcové*) гэсэн санаатай юм. Чингис хаан, өөрийн шөнийн гвардыг дээд зэргээр үнэлэн хэлсэн үг байна. “Миний жаргалтай хэвтүүл” гэж орчуулбал гоомой болно.

– Миний орчуулга:

«миний [надад] өлзийгөө өгсөн (*ölzeiten*) хэвтүүлийг минь ивээгч/аврагч/ хэвтүүл гэгтүн».

– Орос: «О благовещий ты мой, Кебтеул!

Славьте же старую стражей ее!» (шүлэглэсэн орчуулга нь);

«Благословенная стража моя!

Называйте же ее старую стражей» (үгчилсэн орчуулга нь) (Козин С., p. 172, 173).

- Чех: «Moji št'astní noční strážcové, vy, starou stráží se jmenujtež!» (Pouca P., p.174).
- Англи: «My happy nightguards, [Henceforth,] call [ye yourselves] the 'elder nightguards' (Cleaves F.W., 1982, p. 169).

2.4.4. өтөг 4.

Kh. *өтөг*, со. мо. *ötüg* 'manure, dung, humus; fertilizer; fine manure Dust which covers places where cattle were kept' (Lessing F.D., 1960, p. 646)

Үгийн гарал ба утга: анхдагч метафор утга нь *эх этүгэний бууц,ээжсийн / өвгөд дээдэсийн үе дамжсан бууц (Этүгэн, метафор утга I*

а. ба V). Энэ санааг монгол хэлний *өтөг бууц* (өтөгийн/өтөгөсийн бууц) гэсэн хоршоо үг хадгалж байна. Хожим нь хүмүүс малчин болоход тийм бууцанд олон малын баас олон жилээр хуран тогтжээ. Ингээд *өтөг* гэдэг үг одоо а) өвгөд дээдсийн бууц, б) малын (хонь ямааны) хатаж хурсан баас гэсэн утгатай байна.

2.4.4.1. Хөх өтөг (тэмдэглэл)

Монголын нүүдэлчид “*хөх өтөг хүүхдэд ээлтэй*” гэдэг. Хөх өтөг гэдэг нь хонины хорголууд өвөлжөөний бууцанд хэдэн жил хатаж хатуураад, хөх өнгөтэй болсон нь юм. Тэдгээрийг төрөх эхийн доор дэвсэж өгдөг. Эх тэр хөх өтөг дээр араг түшиж хоёр өвдөгөөр сөхрөн сууж төрнө. Малчидын итгэлээр бол “араг зовлонт сав (араг бол хүнд ачаа тээхийн зовлонтой) болохоор төрөх эхийн өвдөхийн зовлонг зайлуулна (өөртөө авна). Хөх өтөг, хүүхдийн эрүүл мэндийг хамгаална” гэх аж. Хөх өтөг, нар салхинд удсан тул ариун цэвэр зүйл байж болно. Гэвч гол юм нь хүүхэдийг муу юмнаас хамгаалах *өтөг* (этүгэн эх, өтөгөс эхийн бууц) –ийн бэлгэдэлтэй холбогдох болов уу. Хүүхдийн эхэсийг гэрт нь эхийн төрсөн тэр газар нь нүх ухаж булдаг заншил байсан. Энэ ч бас эх этүгэний ивээлийн бэлгэдэл буй заа.

2.4.5. өтөг 5.

Үгийн гарал ба утгын тайлбар: *Этүгэн, метафор утга IV.*

а) Тайлга тахилгын өргөл. Жишээ нь Kh. *өтөг*, Cl.Мо. *ödke* 'offering, sacrifice'; *morin ödke* 'horse used in sacrifice made to Chinggis Khan' (?) (Lessing F.D., 1960, p. 629).

б) Тайлга тахилга, эрхэм ёслолын ширээний идээ, эрхэм хүндэт хоол унд (хонины мах, цагаан идээ, архи, айраг, бас тэдгээрийн хэсэг) гэсэн утгатай байв. Одоогийн халх аялгуунд тэр утга нь мартагдаад *айраг зэрэг шингэн юмны тунасан өтгөн, нитгэл* гэх утга үлджээ.

Тэнгэр нарт (жишээ нь Арван гурван Атаа Тэнгэр) ба Онгонд (жишээ нь Чингис хааны онгон) улирал тутам тахил өргөх тухай Дээрээс тогтоосон ёс журам³², зан үйлийн уламжлалд тахилгын идээг *өтөг* гэж нэрлэдэг байжээ. Чингис хааны төрсөн өдрийг

³² Монголын эзэнт улс, 1295 онд *Тайлгын яам* гэгчийг байгуулж Чингис хааны Онгоныг тахих ажлыг хариуцуулав. Тэнгэр нар ба онгод, шүтээдийг тахих ажлыг ерөнхийд нь тэр яам эрхэлдэг байсан бололтой. Үзэмүү Нямбуу Х., 1992, р. 26-28, р. 103-104.

тэмдэглэх (*tasam-a talbiqu*) өвөлийн тахилгад “нэг гүү, есөн хонин өтөг, есөн хэм”³³ архи ордог”(Нямбуу Х., 1992, р. 150).

Дундад үеийн монгол хэлний дурсгалд *ерөөлийн хундага оргох* гэсэн санаатай хэлцэнд тохиолдоно (дараахи тэмдэглэл үзэмүү).

2.4.5.1. Өтөг угсаны хойно (тэмдэглэл)

МНТ-нд *ötög uysan-u qoina* гэсэн хэлц байдаг (§154. L. 23, Sumyabaatar B., 1990, p. 323). *Ötög uy-* гэсэн холбоо үгийг хятад эхийн хадмал орчуулгад «*ariki oruyulqu*» (архи оруулах-) гэсэн аж (Čeringsodnam D., 1993, p. 374, see note 255). Гэвч орчуулагчид *uy-* гэдэг үйл үгийг *уу-* (Cl.Мо. *uuyu-*) ‘to drink’ гэсэн үг мөн гэж үзэв. Тэгээд «после того как выпита чара-оток» (Козин С., 1942, р. 124), «*u konce a nároj vyvit*» (Poucha P., 1955, p.87), «after we shall have drunk the *ötög** [this word is glossed “wine which is offered”]» (Cleaves F.W., 1982, p.83) орчуулав.

Бидний үзэхээр бол *ötög uy-/oy-* гэдэг нь хэлц үг байна. *Uy-/oy-* гэсэн үйл үг одоо мартагдсан боловч Kh. *уэз тата-* ~ *уэзра-* ‘to pull or jerk’, *ухасхий-* ‘to dash forward, jump up from one’s place’, *огзом/огцом* ‘abyss, steep slope, abrupt[ly]’, Cl.Мо. *oysi-* ‘to bulge up’, *oysiida-* ‘to be thrown out’ зэрэг үгсийн *уэ, ух, үэ, оу* язгууруудын илэрхийлж байгаа “агшин зуурын түргэн үйлдэл”-ийг заах утганаас мэдэгдэх бололтой.

Тэгээд *ötög uy-/oy-* гэсэн хэлц бол үндсэн утга нь *өтөг* (архины дээжийг) *саца-/өргө-*; метафор утга нь *ерөөлийн буюу ёсны хундага өргө-* гэсэн санаа юм. Хятад хадмалын орчуулга учиртай байна.

2.4.6. өтөглүүл-

Өтөг (өтөг 3, өтөг 4, өтөг 5) гэсэн нэр үгнээс *өтөглө-* (метафор утга нь *тусгай эрх бүхий бодгали болго-*) , *өтөглүүл-* (*өтөглө-* ийн үйлдүүлэх хэв) гэсэн үйл үг бүтнэ. *Өтөглө-* гэдэг үйл үгнээс бүтсэн *ötökülekün* (*өтөглөхүн*) гэсэн үйлт нэр МНТ-д байдаг (Sumyabaatar B., 1990, p. 646, §227, L.2). Судлагч, орчуулагчид энэ үгний тухайд нэгдмэл саналтай, “дарга, elders” гэж орчуулдаг.

Юан улсын хааны зарлигуудад³⁴ «*Сэниингүдийг өтөглөж*» [*sè,n-šhi-ŋu-di* “*eo-t’eo-gu-le-ju*”³⁵ (Жанчив Ё., 2002, р.23)] ‘*Даос хуврагуудад тусгай эрх олгож*’ гэсэн хэллэг (*өтөглө- < өтөг 3*) гурван удаа тохиолдож байна.

МНТ-д *ötöglegüľžü* Cl.Мо. *ötüglegüľjü* (§187, L. 5; §189, L. 6; §219, L.17) гэдэг үйл үг бий. Бидний үзэхээр бол энэ үйл үг. *өтөг 4* -өөс ирсэн тул одоогийн монгол хэлээр *өтөглүүл- / өтөглөгдө-* (*өөртөө тавиг тайлга хийлгэ-*) гэсэн санаа юм.

МНТ-ны бичвэрт «*qorcilayulžu ötöglegüľžü... žiradqun*» (Sumyabaatar B., 1990, §187, L. 5-6, p.447) гэсэн хэлц бол «*[Ta хоёр] [өөрийгөө] хорчилуулж (хорчин нараар хамгаалуулж), [өөрийгөө] өтөглүүлж (өөрийгөө тайлгаж / өөртөө тавиг тайлга*

³³ Хэм гэгч нь архины савны нэр бололтой. Утга тодорхойгүй.

³⁴ Дөрвөлжин үсгээрхи (HP’AGS-PA SCRIPT) Мангалын зарлиг (1276), Буянт хааны зарлигт (1314) үз.

³⁵ «*öt’ögüle(ju)* to head, be at the head of, bet he senior || Мо. *ötegüle-*» (Poppe N., 1957, p. 128).

үйлдүүлж) ... жаргагтун»³⁶ гэсэн утгатай юм. Чингис хаан, өөрийнхөө амийг аварсан хоёр адуучин эрд онц эрх олгож хэлсэн үг байжээ.

2.4.7. өдгөө

Энэ үг бол *этүгэн* (*өтөг...*) гэдэг үгийн төрөл арилжисан дүр юм. Эх үгийн хувьсалын түүхэнээ илэрсэн бүх салаа утгасаас бүрэн чөлөөлөгдөөд, монгол хэлтэний өдөр тутамын хэрэглээний эрх чөлөөт үг болчихоод байгаа нь аж. CL.Mo. *edüge*, дуудалга нь [эдэвгээ, өдгөө, одоо]. Бичиг огт мэдэхгүй монгол хүн, хурал цуглаан дээр үг хэлэхдээ «эдэвгээ миний бие болбоос» (Заа би бол) гэж хэлэхийг Б. Я. Владимирцов соноссоноо тэмдэглэсэн байдаг. «Одоо бол, одоо» гэсэн үгийг амны уншилга болгосон хүмүүс одоо үед ч байна. *Этүгэн* (*өтөг...*) гэдэг үгийн хэрэглээний цагийг эзэлсэн давтамж, санамсаргүй давтагдаж байгаа нь бололтой. Энэ үгний гаралын талаар «*etügen : itügen – edüge*» (Владимирцов Б., 1989, р. 155) гэсэн тэмдэглэл байдаг.

3. Эх гэдэг үгийн үүсэл хувьсал

Одоогийн монгол (халх) хэлэнд эх гэдэг үг: а) ээж, б) эхлэл гэсэн хоёр утгатай. CL.Mo. *eki* (эхлэл), *eke* (ээж). Дундад үеийн монгол хэлний баримтад бас тэгж байхаас гадна *eke etügen* 'Мать-Земля' (МНТ, §113), *etügen eke* 'материнственная земля' (МНТ, §255) гэсэн хоршоо үгээр гардаг.

Eke гэдэг үгийн анхдагч үндсэн утга, шилжмэл буюу метафор утгас салаалсан байдал ба, тэдгээрийн хэрэглээ нь ч гэсэн *etügen* гэдэг үгийн үүсэл хувьсалын явцтай тун адил.

Үгийн гарал ба утга

а) Монгол хэлний түүхэн авианзүй судлалын үзэлтээр бол эгшигээр эхэлсэн олон үгийн эхэнд эрт цагт **p*, **k*, **t* авиа байсан. Жишээ нь:

«АМо. **peki* (n) 'head' > Ма. *fexi* 'brain, memory', cf. Му. *hekin* 'head', Scr.Mo. *eki*(n), 'head, beginning', Kh. *эх* 'beginning'» (Poppe N., 1999, р.8)

Энэ үзэл баримтлалын дагуу эх гэдэг үгийн гарал нь:

**peki* > **beki* > **keki* / *keke* > *heki* / *heke* > **eki* / **eke* > эх гэж тодорхойлж болох юм.

б) *Eke* (ээж) гэдэг үг, *eki* (beginning) гэдэг үгнээс ирсэн гэдэг. Энэ бол аксиом. Гэвч энэ үгний анхдагч утга нь юу байсан бэ гэдэг бол оньсого. Жаахан фредист үзэл санаагаар бодвол *eke* > *eki* гэдэг үгний анхдагч утга нь *etüge(n)* үгний нэгэн адил эмийн тэмдэг эрхтэний нэр байсан бололтой. Ингэж хэлэхийн үндэс нь одоогийн монгол ярианы

³⁶ Англи орчуулга нь „[With my] suffering [you] to carry quivers and suffering [you] to drink *ötög*” (Cleaves F.W., 1982, p.114, §187). Чех орчуулга “*Dávám vám oběma pravo nosit toulec a pít z poháru*” (Poucha P., 1955, p.119, §187). Орос орчуулга „И пусть пользуются свободным дарханством, повелевая своим подданным носить свой сайдак и порвозглашать чару на пирах” (Козин С.А., 1941, р.141, §187).

Орчуулагчид энэ базаахгүй орчуулгаа МНТ-ны §219-д бас давтсан.

Гэвч §189-д байгаа (*Ван хааны толгойг*) *ötöglegülzū* гэдэг үгийг “making [one] to present the *ötög*” (р.116, Cleaves 1982), “стали совершать пред нею жертвоприношению” (р.142, Козин 1942), “*zařidila pítí vína*” (Poucha 1955, р. 121) гэж аятайхан орчуулав.

хэлэнд байгаа «*ацын эх*»³⁷ гэдэг хэлц юм. *Ац* гэдэг нь үгчилбэл *салаа* /'fork, bifurcated branch of a tree'; шилжмэл утгасын нэг нь *салмаа* 'crotch between the legs, perineum (anat.)'; –ын харьяалахын нөхцөл (suffix of genetivecase); *эх* гэдэг үг: а) *эхлэл* 'beginning', б) *толгой, түрүү* 'head, top' гэсэн утгатай болохоор энэ хэлцийн утга нь *vulva* бололтой юм.

3.1. Keke

Eke гэдэг үгний гарвалзүйг нарийн тогтооход туслах үг бол МНТ-ны *keke* гэсэн үг юм:

– *kegeli nigeten* (хээл нэгтэн)

keke yarčatan (хэхэ ганцтан), (Sumyaabaatar B., 1990, p. 197, §121, L.2-L.3). Англи орчуулга:

“The [mother’s] belly [was] one [and the same]
[and of whom]

The water of the mother’s womb [was] an only [one]” (Cleaves F.W., 1982, p.53). Чех орчуулга:

“z jednoho života,

z jedné plodové vody” (Poucha P., 1955, p.57). Орос орчуулга:

“Чрево одно

И сорочка одна.” (Козин С., 1942, p.107).

Орчуулагч нар, МНТ-ны *keke* гэдэг үгний хятад хадмалд байгаа “*qoyituki-yin singgen*” (Čeringsodnam D., 1993, p.339, note 175) гэсэн орчуулгыг үндэс болгов. Д. Цэрэнсодном түүнийг батлаад, *keke* гэдэг үгийг одоогийн Хуучин Барга ба Найманы аман аялгуунд *kekei, keki* (хэхэй, хэхий), халх. *эхэс* гэдэг үг мөн гэж үзэв (Čeringsodnam D., 1993, p.339, note 175). Ш.Гаадамба *keke* гэдэг үг бол *эх* гэдэг үгний эртний дуудлага мөн, МНТ-ны дээрхи хэлц бол “нэг овог төрөлд хамаатай, төрөл садан” гэсэн утга санаатай, эхийн эрхэт ёсноос уламжилсан цэцэн үг гэж үзсэн юм (Гаадамба Ш., 1976, p.159).

Эх (ээж) гэдэг үгийг МНТ-д *eke* гэж бичдэг юм. Гэтэл зөвхөн нэг удаа *keke* гэж бичив. Үүний учир нь *Qorči* гэдэг нэг ноён өөрийн үгийг Тэмүжинд итгүүлэхийн төлөө эртний уламжлалт *омогос үгсийг*³⁸ эш татсанд байна. Тэр уран хэлцэд (экспрессив идиом) *kegeli* ба *keke* гэсэн толгойн холбоц «*ke*» байгаа болохоор тухайн үеийн амьд хэлний *eke* юмуу *ekes* зэргийн бусад үгээр сольсонгүй. МНТ-д нүүдэлчдийн нэн эртний (13-р зуунаас олон зуун жилийн өмнөх) аман бичвэр³⁹ олон байгаагийн нэг нь энэ идиом ажээ.

³⁷ Энэ хэлц бол хараалын чанартай юм. Хэрэглээ нь: «*ацынхаа эхээр хийнэ дээ чи!*», «*ацын чинь эх!*» гэлцэнэ. Ахмад хүн, голдуу эмэгтэй хүүхдэд ингэж хэлдэг.

³⁸ *Ötöküs üges* (МНТ §78, 260) – үгчилбэл *хөгшидийн* үгс, метафор утга нь *сүлдэрт үгс* (хүний сэтгэлийг хөдөлгөн чадагч, *овгод дээдэсээс заяасан* үг, хэллэг).

³⁹ “Изучая эти «устные письма» в составе «Сокровенного сказания» или параллельных ему записей Рашид-Элдина, мы приходим к заключению, что они принадлежат к специфически-кочевым жанрам монгольского народного творчества, различные элементы которого проникают всю ткань «Сокровенного сказания», как и позднейшей монгольской летописи, унаследовавшей все основные черты этой начальной монгольской хроники. Устные письма эти представляют такое же устное народное творчество, как и включенные в памятник многочисленные пословицы, поговорки, изречения и гномы, лирические народные песни, отрывки исторических песен, былины, фрагменты эпических циклов и т. п. ...

Ингээд эртний тэр **keke* > *eke* гэсэн хоёр үгийн үндэснээс цаашид ямар ямар үг салаалж, метафор утга төрсөн бэ гэдэг нь их сонирхолтой байна. Бидний үзэхээр бол:

- **keke/gege* гэдэг үгний анхдагч бод утга нь *зай завсар*, *нүх* гэсэн утга байсан бололтой. Ингэж бодохын үндэс бол монголчуудын элэнц эх Алангоо, Тэнгэрээс жирэмсэлсэн тухай домогт гарсан *erüke totuγ-a-yin gege-ber* (*өрх томгын гэгээгээр*) гэдэг холбоо үгэндхи *gege* (*гэгээ*) гэсэн үг юм.

Тэр үгийн *keke* гэсэн уншилга дуудалга мартагдаж *gege* (бүдэг гэгээ орох завсар, *нүх*) гэсэн дуудалга МНТ-ны доорхи бичвэрт үлджээ.

Бичвэр:

“*Sünid büri čegen šira kügün ger-ün erüge dotoγa-jin **gege**ger orožu kegeli min-u biližü gegegen in-ü kegeli-dür min-u šingekü bülege. Garurun naran sara-jin kili-ger šira noγai metü sičabalžan γarqu bülege...*” (Sumyabaatar B., 1990, p.23-24, §21, L.1 – L.4)

“*Every night, a bright yellow man entered by the light of the hole at the top or [by that] of the door top of the tent and rubbed my belly. His light was wont to sink into my belly. When he went out, like a yellow dog he was wont to crawl out by the beams of the sun or moon.*” (Cleaves F.W., 1982, p.4)

Дээрхи холбоо үгийг чех хэлэнд “*střešním otvorem*” (Poucha P., 1955, p.13), орос хэлэнд “*через дымник юрты*” (Козин С., 1942, p. 81) гэв.

– *erüke-yin gege* гэдэг нь монгол гэрийн өрх, тооныг бүрэн хааж чадахгүй тохиолд илрэх багахан завсар юм.

– *totuγ-a-yin gege* гэдэг нь гэрийн эсгий дээвэр, тотгонд хүрэхгүй тохиолд гэрийн унины бөгс ба тотгын дээр харагдах хэдэн багахан *нүх* юм.

Эртний энэ язгуур утганаас салбарлан хөгжсөн олон үг үзүүлж болно:

gege(n) / *gegege(n)* ‘daylight; morning dawn; light; splendor, brightness; heart, mind (honorific); bright, brilliant, serene’ (Lessing F.D., 1960, p.373); *gegebči* ‘window’; *gege-* ‘to abandon, give up, leave, reject; to lose’; *gegere-* / *gegegere-* ‘to dawn grow light; to become enlightened or cultured’

3.2. **Beki* > *keke* > *eke* гэдэг үндэснээс төрсөн үгс

3.2.1. гэгэй

«*gegei*» *kemegči keüked-i törün γaryaqu-du urida γarči qayaran usu γarday γayum-a-yi kelen-e. Jarim γajar basa «ikes» gen-e* (Vangjil B., 1987, p.427) Энэ үгний хувилбар нь Хуучин Барга аман аялгуунд «*kekei*», Найманы аман аялгуунд «*keki*» аж (Čeringsodnam D., 1993, p.339, note 175).

Это-то устно-литературный сверхдиалект *хоин* и берется главным творящим элементом в основу письменного монгольского языка, а из письменных форм, при ограниченности и малой сохранности и подвижности их, снова возвращается в устную среду для того, чтобы отсюда снова отлиться в письменные памятники.” (Козин С., 1942, p. 50)

3.2.2. хээл

- Дундад үеийн монгол хэлний *kegeli* (МНТ-ны хятад галигт *k'èlǐ*), Cl.Mo. *kegeli*, үндсэн утга: *гэдэс*, метафор утга: *эхийн умай, сав, хүүхэн хэвтэш* (Цэвэл Я., 1966, p.754)
- Kh. *хээл*, Cl.Mo. *kegel*, үндсэн утга: *гэдэс*, метафор утга: *эм амьтаны хэвэл дотор тогтсон үр зулзага*;
- Kh. *хэвэл / хэвлий*, Cl.Mo. *kebeli < kegeli*; үндсэн утга: *гэдэс*, метафор утга: а) *умдаг*, б) *эхийн умай, сав, хүүхэн хэвтэш*;

Хуучин цагийн (18 зуун) толь бичигүүдэд тайлбарласан нь:

- «*Ayuuliqai-ača doruysi-yi anu kebeli kememüi. Küisün-ü dooradu-yi bay-a kebeli kememüi*» (QORIN NIGETÜ, 1979, p.344)

- «*bay-a kebeli basa umaday kememüi*» (TABUN KELEN-Ü TOLI, 1957, I, p.1295)

Ингээд, МНТ-ны §121: *kegeli nigeten*
keke yačatan

гэсэн өвөрмөц хэлцийн метафор утгыг одоогийн монгол хэлээр: “умай нэгтэн, үтрээ ганцтан” буюу “нэг эхийн саванд хүн болж нэг үүдээр төрсөн” гэж; нөгөө §21-ийн:

“*Sünid büri čegen šira kügün ger-ün erüge dotoya-jin gegeger orožu kegeli min-u bilizü gegege in-ü kegeli-dür min-u šingekü bülege...*” гэсэн хэсэгийг “Сөнө бүр цэгээн шар хүн, гэрийн өрх тотогын нүхээр орж ирээд хэвэлий умдагий минь илэхэд гэгээ нь саванд минь шингэдэг билээ” гэж би хөрвүүлж байна.

3.2.3. гээгээ

Cl.Mo. *gege*, хуучирсан үг: *хаад ноёдын охин* ((Цэвэл Я., 1966, p.172); манж. *хехе* (эхнэр, авхай) ‘woman, wife; princess’.

3.2.4. ихэс

Kh. *ихэс*, Cl.Mo. *ikes* ‘caul, ammion, placenta’. Үгийн гарал: **kekes > ekes < eke+s* (олон тооны нөхцөл).

3.2.5. Эх

Eke гэдэг үг, дундад үеийн монгол хэлэнд үндсэн утга нь а) *эх, ээж*, б) *эрхэм хүндэт эх*; шилжмэл утга нь а) *шүтээн: ээлтэн, ивээлтэн / ивээгч* (жишээ: *Eke Onan* ‘Mother Onan’ – МНТ, §75; *Eke Etügen* ‘Mother Earth’ - МНТ, §113), б) *газар, дэлхий* (жишээ: *Ötögen eke aui bei* ‘манай дэлхий уудам байна’ – МНТ, §255).

Сүүлчийн энэ метафор утгын (b) бас нэг сонин жишээ МНТ-ны §238-д байна: Уйгурын хаан Идук-хут *Iduq⁴⁰ qut*, Чингис хааны нэр алдарыг сонсоод ямар ч

⁴⁰ Уйгур хэлний энэ үгийн гаралыг *Etügen/Iduyan > Iduq* гэж би үзнэ.

эсэргүүцэлгүйгээр шууд дагаж орохоор шийдвэрлээд түүнд элч явуулж хэлсэн магтал үгэнд:

«Egülen arilžu

Eke naran üžegsen metü

Mölsün arilžu

Müren usun olуysan metü

Čingis Qaγan-u nere aldar sonosču maši bajasha» (Sumyabaatar B., 1990, p.677, §238, L.3 – L.5).

Энэ уран шүлэгийн дөрвөн мөр тус бүр нь “өгүүлэгдэхүүн + өгүүлэхүүн” / “subject + predicate” бүтэцтэй. Мөрүүдийн эхэнд байгаа: *egülen, eke, mölsün, mören* гэсэн үгс бол өгүүлэгдэхүүнүүд байна.

Еке гэдэг үгийн метафор утга бол *газар дэлхий*, mören гэдэг үгийн метафор утга нь *голын голдрил, сав* юм. Ингээд тэр дөрвөн мөртийг одоогийн монгол хэлээр:

“Үүл арилж

Газар, нарыг үзсэн мэт

Мос хайлж

Голдрил, усыг олсон мэт

Чингис хааны нэр алдар соносч маш баясав” гэж хөрвүүлж болно байх. *Газар* гэдэг үгний оронд *Дэлхий, Эмүгэн* эх гэдэг үгийг тавьж болно.

Орчуулгын жишээ

Англи: “[Even] as having seen Mother Sun,

When the clouds become clear;

[Even] as having found the water of the river,

When the ice becometh clear,

I greatly rejoiced, when I heard the name and the fame of Čingis Qa'an.” (Cleaves F.W., 1982, p.172)

Чех: “Je to,

jako když mraky se protrhnou,

matku slunce zase je viděti,

jako když ledy se protrhnou,

voda řiční zas najd se.

S velkou radostí doslechl jsem se o jménu a slávě Čingis chahanově.” (Poucha P., 1955, p.177)

Орос: “С великой радостью слышу о славе Чингис-ханова имени! Так ликуем мы, когда рассеются тучи от себя матерь всего – солнце.

Так радуемся мы, когда пройдет лед откроются вновь воды реки.” (Козин С., 1942, p. 174).

3.2.6. Ээд

Үгийн гарал: *Eke > *ebe > ege > ehe > e'e > ee (Ээ).

Үгийн бүтэц нь: ee + d ~ de (олон тооны дагавар). Санаа нь ээд = ээнүүд, ээс.

ММо. e'ede ~ egedе (МНТ §105, 109). СМо. egedе, eged (ege de / ege te) – (Lu. Altan tobči, p.26, p.27.); Үндсэн утга нь «ээлтэн, ээлээ огогч, ивээгч, ээгч» ‘protectors, patrons’. Метафор утга нь «сахиус, шүтээн, хайрхан, богд».

Энэ үгийн үндэс одоогийн хэлэнд *ээ-* (*ege-*) гэдэг үйл үгээр байна. Нэр үгээр эртний монгол хэлэнд байсан нь тэр *e'e ~ ege* (ээ) ажээ.

Тэр үг МНТ-ны -д хятад эхдээ *éétié* гэсэн галиг бичээстэй (Sumyabaatar B., 1990, p.154, §105, L.28, L.30; p.164, §109, L.3, L.5), *майхны гол тулгуур* гэсэн хадмал хятад орчуулгатай (Гадамба Ш., p.276, тайлбар 370) байна.

Ээд гэдэг үг одоогийн монгол хэл аялгуунууд ба толь бичгүүдээс олдохгүй болохоор МНТ-ны орчуулагч судлагч нар, түүний хятад орчуулгад ханджээ. Ц. Дамдинсүрэнгээс бусад хүмүүсийн орчуулгад тэр үгийг: *майханы гол тулгуур, гэрийн барилгын чухал хэсэг, их хаалга, цонх, гэрийн яс мод* гэх зэргээр ойлгож орчуулдаг нь ойлгомж муутай юм.

Хятад хадмал орчуулгаас илүү чухал зүйл бол түүний хятад үсгийн галиг байна. Ээд гэдэг үгэнд задлаг хийж, мартагдсан утгыг сэргээн олох боломжтой юм. Үүнд,

а) *Ee* (Ээ) гэдэг үг бол “буриад домогзүйд «*Ee – Qayiraqan* (Ээ – Хайрхан)», «*Egegen yeke burqan* (Ээн их бурхан) гэдэг нэртэй, ертөнцийг бүтээгч Тэнгэрийн нэрэнд” (Dulma S., 1999, p. 191) байна!

Ээ – Хайрхан гэдэг үгний «Ээ» нь одоогийн монгол хэлэнд тодорхой утгагүй аялга үг гэж бодогддог. Уг гарал нь тийм биш. *Ээ* гэдэг нь *Хайрхан* гэсэн утгатай тусгай үг байжээ. Одоо ч монгол ярианы хэлэнд *Ээ бурхан минь!*, *Ээ зайлуул* гэх зэргийн хэллэгт байсаар байна.

МНТ-ны *E'ede* (Ээд) гэдэг үг бол *Хайрханууд* гэсэн үг болох нь гарцаагүй.

б) Тэр сонин үг одоогийн монгол хэлэнд мартагдасхийсэн боловч түүний төрөл садан үгсийн үндэс ба утгас олон байна:

- Kh. *ээж* (Cl.Mo. *ejī*) ‘mama (familiar term)’ (Lessing F.D., 1960, p.377)
- Kh. *ээ-* (Cl.Mo. *ege-*) ‘to warm’ (Lessing F.D., 1960, p.296)
- Kh. *ээл* (Cl.Mo. *egeli*) ‘счастье’, *ээлтэй* ‘приносящий счастье’ (Лувсандэндэв А., 1957, p. 684)
- Kh. *ээг* (Cl.Mo. *egeg*) ‘place exposed to the sun, but protected from the wind; covered or sheltered place’ (Lessing F.D., 1960, p.297)
- Kh. *ээээрэл* ‘желание; надежда, ожидание’ (Лувсандэндэв А., 1957, p. 666)
- Kh. *эээ л* (Cl.Mo. *egele, egege le*) ~ *золтой л* ‘к счастью!’
- Kh. *эээ* (Cl.Mo. *eg-e*) – юманд унаж өвдөхөд сочин гаргах аялга (Цэвэл Я., 1966, p. 869). «*Бурхан минь!*» гэсэн санаатай энэ аялга үгийг «ээ!», «ээ-гээ!», «ээ-гэгээ!», «ээг-ээ!», «эг-ээ!» гэх мэтээр халхын олон газар нутагт одоо ч хэлсээр байна.

МНТ-ны *ээ* (ээд) гэдэг үг бол тэр үеийн мэргидүүдийн гэрт болон гадаа чингэлэгт залаастай байсан бүх бурхан шүтээний ерөнхий нэр байжээ. Түүхийн болон угсаатаны зүйн тэмдэглэлүүдэд байгаа мэдээнүүдээс үзвэл эртний монголчуудын тэр Ээд (Хайрханууд) гэдэг нь ихэнхдээ, янз бүрийн материалаар (торго, исгий, мод, хүрэл гм.) хийж чимсэн онгодын дүрс байсан. Тэдгээрийн байрлал нь:

- эр нөхөрийн талын сахиус (*egé, e'e*) гэрийн баруун хойморт, эхнэрийн талын сахиус гэрийн зүүн хойморт, гэр бүл нийтээрийн сахиус нь гол хойморт байрласан байдаг,
- малын хэшиг өгөгч сахиус (*jaγaγai*): нөхөрийнх нь баруун хатавчинд (гүүний дэлэн дүртэй), эхнэрийнх нь зүүн хатавчинд (үнээний дэлэн дүртэй) өлгөөстэй байсан,

- өвгөд дээдэсийн нь шүтэж явсан дурсгалт сахиуснууд гэрийн гадаа, тусгай чингэлэгт тэргэнд хадгалаастай байсан зэргийн сонин баримтуудыг 13-р зуунд Монголд очсон өрнөдийн жуулчины тэмдэглэлд⁴¹ үзэж болно.

Бичвэр:

*Tere kökideg Toytaṣa-jin erüge degere in-ü oruṣu*⁴²

Erkin egedе inü

Embürü dayariṣu

Eme kögün inü

Ecültele qayuluja;

Qutuy egedе inü

Quyuru dayariṣu

Qotola ulus-i inü

Qoyosun boltala qayuluja. (Sumyabaatar B., 1990, p.154, §105, L.28,L.30)

Зарим үг хэллэгийн тайлбар:

– *embürü dayari-* (Kh. өмбөр дайра-); *embürü* / өмбөр гэсэн үг одоо алга болсон мэт боловч өмбөрч бөмбөрө- гэсэн хоршоо үгнээс монгол хэлтэнд амархан ойлгогдоно. Тэгээд: «тэдний эрхим шүтээнүүдийг [бидний цэрэгүүдийн хөлөөр] өмбөрч бөмбөртөл (хөлөөр хөглөртөл) дайръя» гэж орчуулуштай.

– *Eme kögün inü ecültele qayuluj* (Kh. эхнэр хүүхэдий нь эцэслэтэл хуулъя):

Eme kögün гэдэг хоршоо үгийн утга нь эмэгтэйчүүд ба хүүхэдүүд.

Qayuluj (хуулъя) гэдэг үгний эртний метафор одоо мартагдсан боловч үндэс нь Kh. хуу (бүгд, цөм, булт) гэсэн үгэнд байна.

*Qayut*⁴³ /хуул- гэсэн үгний гарал нь хуу- (мөхсөн үйл үндэс) + л- (давтан үйлдэх болцын нөхөцөл). Хуулъя гэдэг нь Kh. цуу > цуул- > цуулъя, цоо > цоол- > цоолъё гм.

⁴¹ Жиованни Дель Плано Карпини, *Монголчуудын түүх*; Гильом Де Рубрук, *Дорно этгээдэд зорчсон минь*, Улаанбаатар, 1988. Карпини Дж. и Рубрук Г., *Путешествие в восточные сираны*, М., 1957.

⁴² *erüge degere in-ü oru-* (Kh. өрх дээр нь оро-) гэдэг бол *Erüge[erüke] degere in-ü oru-* (ха. өрх дээр нь оро-) гэдэг бол хэл шинжлэлд нэрлэдэгээр “гаж танхай өвөрмөц хэлц” (deformation of idiomatic expression) юм. Метафор утга нь *гэв гэнэт дайра-, яах ийхийн зуургүй дайра-, хий хуй шиг дайран оро-*; С. Козины орос орчуулга (*Бурея внезапно грянем.*) аятайхан юм. Гэвч түүний дагалт үгчилсэн орчуулга (*обрушившись на него прямо через дымовое отверстие*) ба П. Поухагийн чех орчуулга (*do otvoru pro dým vlezeme* – „утаа гардаг нүхээр бид орно“), Ф. Кливесийн англи орчуулга (entering [as one might say] upon the hole at the top of his tent – “гэрийн нь оройд буй нүхээр орно”), Оргонгөө Ононы англи очуулга (we shall drop through your smoke-hole – “утааны нүхээр нь бид орно”) (Urgunge Onon, 1993, p.30) – монгол хэлтэнд бол инээдтэй юм аж. Орчуулагч нар, уг хэлцийн *oru-* (ха. оро-) гэдэг үйл үгний үндсэн утгад (*to enter*) баригдсан бололтой. *Oru- /opo-* гэх үйл үгний шилжмэл утгад *bayu-/буу-* гэх санаа байдаг (жишээ нь *хур оро- /хур буу-*) болохоор Д. Цэрэнсодномын “*erüken deger-e ni bayuju /өрхөн дээр нь бууж*” гэсэн орчуулга оновчтой байна. МНТ-ны *Erüge[erüke] degere in-ü oru-* гэдгийг европын хэлнээ үгчилэн орчуулснаас, *нэлмэг тэнгэрийн аянга бол-* (жишээ нь чех хэлээр *Rána z čistého nebe*) гэсэн шиг орчуулбал арай дээр болохсон болов уу.

⁴³ МНТ-ны латин галигт *qayuluja* (Ширатори Куракичи), *hawuluja* (Игор Де Рахевилз) гэх энэ үгийг эртний «а-» гэсэн үйл үгний үйлдүүлэх хэвээс (Lessing F. D., 1960, p.16, aṣul-) ирэлтэй: *a- + ü- > aqül- / ayül- / ahül- / a'ül- / ü- ; aqül- > qül-. Энэ үйл үгийн эртний утга мөхсөн боловч түүнээс үлдсэн *агуулах* гэсэн үгний утгаар хөөвөл: *өөртөө агуулах, өөртөө авах, оорийн болгох, эзлэн авах* гэсэн ойр утгасаар ойлгож болно. Бас түүнээс үлдсэн *уулга*

загвараар бүтсэн үг байжээ. Утга нь одоогийн Kh. хуу хамъя, хуу авчиръя, хуу хураан авъя гэсэн экспрессив хэллэг мөн шиг байна. Тэдний эхнэрүүд ба хүүхэдийг бид хуу өөрийн боол зарц болгоё гэж ойлгоход болно. Дайсан этгээдийн эхнэр хүүхэдийг алж устгах (destroy) явдал байсангүй.

Одоогийн монгол хэлээр бол (миний хөрвүүлгэ):

Тэр хөвсрөг (хөхидөг) Тогтоогийн өрх дээр нь орж

Эрхим сахиусы нь

Өмбөр дайрч

Эхнэр хүүхэдий нь

Эцэс болтол хуу хамъя.

Хутаг сахиусы нь

Хугар дайрч

Хотол улсы нь

Хоосортол хуу хамъя.

Англи орчуулга:

Of that Toyto'a which trembleth,
Entering [as one might say] upon the hole at the
top of his tent
Smiting his weighty tent frame
In such a way that it shall fall down flat,
We shall destroy
Until his wives and sons be extinguished.
Smiting his door frame, which [for him] is a god
which bringeth happiness,
In such a way that it shall break to pieces,
We shall wholly destroy his people,
Until there be [only] emptiness [there]. (Cleaves F.W., 1982, p.43)

Чех орчуулга:

U toho bázlivého Tochtoy
do otvoru pro dým vlezeme,
hlavní sloup jeho stanu
porazíme, až upadne,
ženy a děti jeho
zcela vyhubíme!
Svatý jeho hlavní sloup
přelomíme,
veškerý jeho lid mu
vezmeme a bude tam prázdno! (Poucha P., 1955, p.47-48).

Орос орчуулга:

(эсэргүүцлийг гэнэт очиж дээрэмдэх цэрэг), уулгала- (гэнэт дайра-) гэдгээр ойлгогдох хам бичвэр тохиолдоно.

На Тохтоа, на зачинщика, труса,
 Бурей внезапню грянем.
 В прах обратим и высоких и знатных,
 Жен и детей полоним.
 Мы их святыни растопчем ногами,
 Целым народам в полон уведем.

[У того беспечного Тогтогоя, обрушившись на него прямо через дымовое отверстие, на самое почетное у него налетим и впрах сокрушим. Женщин и детей в полон всех заберем; самое святое у него ногами потопчем, весь народ до конца истребим.] (Козин С., 1942, р. 100 - 101).

3.2.7. Ээнэгч хоймор

Дунд үеийн монгол хэлэнд ийм хэлц байна. *Ээнэгч* гэдэг үгийг МНТ-ны хятад галигаар *éēniēk'(è)ch'è* (Ширатори-ийн латин галигт *egenegče*, Рахевилзийн галигт *e'enegce*) гэж тэмдэглэв. Хятад хадмал орчуулга нь *гол,чухал* гэж байгаа бололтой. Тэгээд *гол/чухал хоймор* гэсэн холбоо үг болно.

Үгийн гарал: *e'e (ege)* 'ээл, ивээл' + *-ne* (үйл үг бүтээгч дагавар) + *-gče/gčī* (үйлт нэр бүтээгч дагавар).

Үгийн утга: 'ээлт, ивээгч, ээл ивээлийг өгөгч'. Холбоо үг: *egenegče qoimar* (ээнэгч хоймор). Холбоо үгийн утга: 'онгод сахиус оршсон, ээл ивээлийг өгөгч хоймор'. С.Мо. *egene-* (kh.ээнэ-) гэсэн үйл үндэс идэвхигүй болсон боловч түүнээс үүссэн *ээнэг* (ижилсэн дасах чанар)⁴⁴, *ээнэгши-* 'to be inspired, be possessed by demons; to be quite confident; to[beme] proud' гэсэн идэвхитэй хэрэглээний үйл үгнээс эртний утгыг ойлгох боломжтой байна.

Бичвэр:

"*Bidan-u uruγ an-dur oduγasu alaγun-a baižu egenegče qoimar qaraqu ažuγu. An-u uruγ bidan-dur iregesü qoimar-a saγužu alaγun-a qaran ažuγu*" (Sumyabaatar B., 1990, р.348, §165, L.5 - L.8).

Одоогийн монгол хэлээр бол (миний хөрвүүлгэ):

"Манай охин, тэднийд очвол алхуунд* байж ээлт хойморыг харах болно. Тэдний охин, манайд ирвэл хоймор сууж алхууныг харах болно".

Үгийн гаралын тайлбар: *alaγun ~ ala'un* (алуун) < *ala* (алцаа, салтаа) + *-γun /'un* (нэр үг бүтээх дагавар). Утга нь *алцаа хэлбэрт газар*. Нэрийн оногдохуун нь гэрийн үүднээс голомт хүртэлхи зай цааш голомтын хоёр талаар салаалж гэрийн хоёр багана хүртэлхи орон зай. Энэ орон зай бол хүний ба өмдний салтаан⁴⁵ (joint of the thighs, groin, crotch) хэлбэрийг эрхбиш санагдуулна. Метафор утга нь *ариун бусын орон*; зарц, доордосын байх, суух газар. Эсрэг үг нь *хоймор (qoimar / qoyimar)*: *ариун газар* – хана ба унind нь тэр айлыг ээнэгч шүтээнүүдийн дүрсийг байрлуулсан, гэрийн эзэд ба хүндэт зочин суух газар юм.

⁴⁴ Монгол хэлний хэл зүйн толь бичиг, II, р. 1308, Хөххот, 2006.

⁴⁵ Үзэмүү Цэвэл Я., 1966, р. 28, үгийн тайлбар: А/II.

Алуун гэдэг тэр үг орчин үеийн монгол хэлэнд нэгэнт мартагджээ. Гэвч тэр үгийг түүнтэй гарал нэгтэй *алхуун* (алха-) + -уун (нэр үг бүтээх дагавар) → *алхах орон зай* гэсэн үгээр сэргээж болно.

Алхуун гэдэг үгний үндсэн утга: *алхах*⁴⁶, *гишгэх газар*; шилжмэл утга: *хөлийн бузартай газар, ариун бусын орон*; зарц, доордосын байх газар (pubic region). *Алхуун* (*alayıun ~ ala'un*) гэдэг бол 1) гэрийн үүднээс голомт хүртэлхи үүд (*egüden*) гэж нэрлэдэг газар. Тэнд хүн суудаггүй. 2) Хоёр хатавчнаас хоёр багана хүртэл, голомтын хоёр талдхи хоёр хэсэг зайн нэр юм. Зүүн орны өмнөх *алхуун* нь эмсийн ажилын байр, баруун орны өмнөх *алхуун* бол эрийн хар ажилын байр ба явуулын хүний суудал болно. Гаданын хүн, айлын баганаас дээш хэтэрэхгүй заншил одоо ч монголд хүчтэй хэвээр байна.

Ингээд, дээрхи бичвэрийн ёгт утга нь: «*манай охин тэдний бэр болбол зарц шиг ад үзэгдэнэ, тэдний охин манай бэр болбол эзэн шиг хүндлэгдэнэ*» гэсэн санаа болно.

Бас МНТ-ны §214-д «*tende sayu kegegdeži höreneži iseri-jin alayun-a üžügür-e sayužu büküi-dür*» [тэнд суу гэгдэж, баруун орны алхууны үзүүрт (орны хөлд) сууж байхад] гэсэн бичвэр бий. Нөхцөлдөлгө нь: татаар аймагийн Харгил Шар гэх дайсан хүн “өлсөөд” Чингис хааны эхийн гэрт ороход эх, “тэнд суу!” гэж баруун орны хөлийн дэргэдэхи зайг заажээ.

Англи орчуулга:

“If a kinswoman of us went unto them, she would stand at the door and would only look upon the back [of the tent]. If a kinswoman of them came unto us, she would sit at the back [of the tent] and look upon the door”* (*By this Senggüm means that, if his younger sister Ča'ur Beki were to marry Joči, she would be treated as a servant who sits just inside the door facing the place of honor at the back of the tent, but that, if Qojin Beki were to marry his son Tusaqa, she would be treated as a lady who sits in the place of honor at the back of the tent facing the door. Cleaves F. W., 1982, p. 89 – 90).

Чех орчуулга:

“Přijde-li některá z našeho rodu k nim, stojí u dveří a dívá se upřeně na hlavní stranu. Když však některá z jejich rodu od nich přijde k nám, sedí na hlavní straně a dívá se k dveřím” (Poucha P., 1955, p. 91-92).

Орос орчуулга:

“Ведь нашей-то родне придется, пожалуй, сидет у вас около порога, да только невзначей поглядывать в передний угол. А ваша родня должна у нас сидеть в переднем углу да глядеть в сторону порога” (Козин С., 1942, p. 127).

Тусгай тэмдэглэл

МНТ-ны хятад галигт эгшиг давхарлан бичих аргаар дундад үеийн монгол хэлний урт эгшишгийг тэмдэглэсэн *é é tié* (ээдэ /ээд), *é é niē k'(è) ch'è* (ээнэгчи /ээнэгч) гэсэн үгс, авсаар ойлгогдохгүй болохоор зарим судлагчид, МНТ-ны уйгур-монгол уг эхийн бичилгийг сэргээн босгох аргад хандана. Тэгээд эхний үгийг *ekede/eked, egüde* гэж сэргээгээд тайлбаруудыг өрнүүлнэ. Хоёрдугаар үгийг *egenegče* гэж сэргээхэд төдий л

⁴⁶ „Үүдний ар юмуу алхаж орох газарыг өгүүлсэн байж болох юм“ (Čeringsodnam D., 1993, p. 383, note 278)

ойлгомжтой биш санагдах тул *egenegte* (Kh. эгнэгт⁴⁷) 'already; completely; always, forever, eternally' гэж тааварлана. Зарим нь бүр кирил үсэгийн бичилгээс монгол бичигээр *egnegte* (Kh. эгнэгт) гэж бичиж сэргээн босгов (Гадамба Ш., 1990, р.90, 1.1798). МНТ-ны *erkin egede, egenegče qoimar* гэсэн үгсийг Lubsangdanjin (17 зуун) *erkin ege de, egegte qoyimar* (Lu.Altan tobci, 1990, р. 27 and р. 58) гэж хуулан бичсэн. Түүнийг тэр, [эрхин ээд, ээгт хоймар] гэж уншсан байх. Одоо ч ингэж унших боломжтой. Хятад галигт монгол хэлний урт эгшиг ба *q/y, k/g* гийгүүлэгчийг ялган тэмдэглэсэн байдалаас үзэхэд үсэгийн ялгах тэмдэг хэрэглэсэн⁴⁸ монгол эх бичигтэй байсан байж магадгүй.

3.2.8. бэх (< beki)

МНТ-д энэ үг, хүний нэрний дараа тохиолдоно. Хятад хадмал орчуулгад түүнийг заримдаа *хүний нэр* (§49), заримдаа *ноёны цол* (§216) гэж тайлбарлав. Судлагчид тэр үгийг түрэг хэлний *beg* 'правитель, вождь, князь, господин' (Наделяев В. М. и др. 1969, р. 91) гэдэг үгээр тайлбарладаг.

Өвөг монгол хэлний **beki ~ *keki ~ eki~eke* гэдэг үг: *эхэн, эх* 'beginning, mother' гэхээс гадна *толгой, тэргүүн* 'head' утга илэрхийлж байсан (Poppe N., 1999, р. 8). Якут хэлэнд *бехи* гэдэг үг: *өндөр, ахмад* гэсэн утгаар байдаг (Cerinsoodnam D., 1993, р. 291, note 43). Тэгэхлээр **pekin > *bekin* гэдэг үг бол *etüken* гэдэг үг шиг эртний хүний соёлын ноцтой үг байсан. Тийм болохоор түрэг хэлний *beg* 'правитель, вождь, бек, князь, господин' (Наделяев В.М., 1969, р. 91) гэдэг үгийн гаралын эх үндэс болсон байж болох юм.

Дундад үеийн монгол хэлэнд (МНТ) *beki* гэдэг үг бол ноёны цол биш, эрэгтэй хүний нэрний хойно байвал *хунтайж* гэсэн утгатай, эмэгтэй хүний нэрний дараа бол *гүнж* гэсэн утгаар байна. **Peki/beki* гэдэг үгний анхны утгасын нэг нь *эрхэм дээд эмэгтэй, тэнгэрлэг эмэгтэй* гэж байсан цагийн дурсгал бололтой. МНТ-д нэрэндээ *beki* (бэх) чимэлгэтэн 12 удаа гарсаны 5 нь эмэгтэй юм. Жишээ:

- *Sača beki*, §122,130 (Сача хунтайж), *Toyto'a beki*, §109, 157, 177 (Тогтоо хунтайж)
- *Alaqa beki*, §239 (Алаха гүнж), *Ča'ur beki*, §165 (Чаур гүнж), *Qojin beki*, §165 (Хожин гүнж), *Ibaya beki*, §186, 208 (Ибага гүнж), *Sorqaytani beki*, §186 (Сорхагтани гүнж).

3.2.8.1. Бэхи мөр (beki mör)

МНТ-ны §216-д: *Üsün* (Үсүн) гэдэг нэртэй нэг өвгөн, өөрийн харсан үзсэн ба сонссон дуулсан юмсын тухай болон өөрийн санаа бодолыг Чингис хаанд айлтган хэлж, зааж сургаж байсан. Чингис хаан түүнийг ихэд үнэлж «монголын ноёдын ёсонд *Beki bolqu* (Бэх болох ~ ноёдын зөвлөгч болгох) гэдэг нэг ёс байдаг билээ» гээд Үсүн өвгөнийг *Beki* (Бэх) болгож, түүнд цагаан дээл өмсгөж, цагаан морь унуулж, хүндэт суудалд суулгаж түүнийг тахиж байх зарлиг гаргав.

Beki гэдэг үгийн эртний утга нь а) *толгой тэргүүн*, б) *эхлэл үүсгэл*, в) *ээж эх*. *Мөр* гэдэг үгийн үндсэн утга нь *зам мөр, замнал* 'way, path (also metaphorically), trace,

⁴⁷ Kh. *эгнэгт* гэдэг үгийг Cl.Mo. *engnegte* гэж бичдэг юм. Зарим бичээч нарын *egenegte, egnegte* гэсэн бичилгэ эргэлзээтэй байна.

⁴⁸ Үсэгийн ялгах тэмдэгийн хэрэглээтэй холбогдсон „үсэгийн эндүүрлийн харанхуй” гэж нэрлэгдсэн маргаан, монгол бичигийн түүхэнд байдаг. Энэ тухай үзэмүү: Lubsangdorji J., 2008.

trail', метафор утга нь *мөрдөлгө заавар* 'guidance, instruction, investigation, interrogation'. Ингээд эртний *Mör beki* (зам заагч эх > зам эхлэгч, зам удирдагч) гэсэн нэр томьёо, нүүдэлийн феодализмийн үед *Beki mör / Mör beki* "Зам заагч багш, зөвлөгч багш" гэсэн утга илэрхийлдэг болсон бололтой. Хааны зарлигт тэр өвгөнийг нэн дээдэлж түүнийг тахих тухай ярьж байгаа болохоор ноёны зэрэг цол биш, *улсын багш* юмуу *дээд зөвлөгч*, гэж ойлгож болно. Зарим орчуулагч "Түүнийг ордны зурхайч болгов" (*Stal se dvorním astrologem*, Poucha P., 1955, p. 249, note 63) гэж аятайхан тайлбарлав.

Бичвэрийн хэсэг:

beki Usun ebügen boltuyai (Sumyabaatar B., 1990, p.616, §216, L.7 - 8).

Миний орчуулга: Үсүн өвгөн Улсын *Бэхи* багштан болтугай!

Англи орчуулга: Old Man Üsün become a *beki* (Cleaves F.W. 1982, p.158).

Чех орчуулга: Starý Usun necht' se stane bekim! (Poucha P., 1955, p.163).

Орос орчуулга: Пусть же примет сан беки – старец Усун (Козин С., 1942, p. 166).

4. Нутаг

Нүүдэлчин монголчуудад нутаг гэж нэг "бурхан" байна. Тэр бол тэдэнд тэдний эх эцэг, үр хүүхэд, ах дүү, найз нөхөд, янаг амрагийг төлөөлнө. Ардын аман зохиолын бүх төрөл зүйл, ялангуяа уртын ба богинын дууны гол оногдохуун нь **нутаг**⁴⁹ байдаг. Эх *нутаг* гэдэг хоршоо үг байна. Энэ нь эртний эх *этүгэн* гэдэг ойлголтын ухамсаргүй залгамж юм.

Үгийн гарал:

Kh. *нутаг*, Cl.Mo. *nutuγ* гэдэг үгийн гаралыг тодорхойлоход хөтлөх хоёр бөлөг үгс байна. Тэр хоёр бөлөг үгс хоёул балар эртний нэг эхтэй (*etüken*) юм. Тэр хоёр нь:

а) «Монголын бөөгийн ёсонд *Натигай*⁵⁰ -*насигай-нэтигэй-нэтүгэй-нэтүгэн-этүгэн* гэх зэрэг олон янзаар бичигдэж ирсэн тэнгэрийн нэр» (Гадамба Ш., 1990, p.394-395, note 646)

б) **nīduyan-nīduyan- *īduyan-iduyan-udayan-uduyan* 'female shaman; midwife' (Lessing F.D., 1960, p.861).

Энэ хоёр бөлөг үгийн утгын холбооноос үзэхэд, *нутаг* гэдэг нь эртний газар дэлхий ч мөн, бас бурхан шүтээн ч мөн ажээ.

Эрт нэг цагт *Nituyan eke, Nutuyun eke* гэсэн холбоо үг байсан, түүнээс *nutuγ* гэдэг үг гарсан буй-заа.

⁴⁹ Монголчуудын *нутаг* гэдэг ойлголтыг этнографийн коммуникацийн талаас судалсан сонирхолтой өгүүлэл үзэмүү: Alena Oberfalzerová, Fear and contentment as experienced by the Mongolian nomads. Nutag, in *MONGOLO-TIBETICA PRAGENSIA* '08, 1/1, Prague, 2008, p. 9 – 43.

⁵⁰ -Монголчуудын гол бурхан/божество *Natigai* (Марко Пологийн ном), *Načiyai eke* (Bodhicaryāvatara-yin tayilburi, by Čos-kyi-odser, in 1312), *Итога* (Плано Карпини) гэх. "Natiyai может быть испорченный Итога. Итога есть не что иное, как Итүгэн, Этүгэн или Этүгэ – богиня земли у монголов" гэж 1846 онд тайлбарласан юм (Доржи Банзаров, *СОБРАНИЕ СОЧИНЕНИЙ*, 348 pp., М. 1955, p. 65-66).

-Умарт монголын Бөөгийн "*Načigajin duudlaga / Invocation de Načigaj*" – 50 мөр шүлэгийн галиг, франц орчуулга, *Načigaj*-н тухай тайлбарыг үзэж болно: EVEN, M-D., 1988-1989, p. 232-235.

5. Төгсгөл

Монгол хэлтэний соёл түүхийн эрхэм нандин үгсийг хүйсийн бэлгэсийн нэртэй холбох нь эргэлзээтэй, сэжигтэй юм биш үү? Судлахын явцад тийм бодот холбоо өөрөө аяндаа гараад ирж байгаа болохоор одоо яая гэх вэ. Тэгвэл таны энэ бичвэр Фрейдизм байна уу? Фрейдизм гэж юу байна? «Фрейдизм – учение австрийского психиатра и психолога З. Фрейда (1856 – 1939), сводившее явления культуры, социальную жизнь, поведение людей к формам проявления первичных, бессознательных жизненных влечений (особенно половых), умаляющее значение разумной деятельности и игнорирующее решающую роль социальных условий жизни людей» гэх – коммунист сурталын үнэр бүхий тайлбар аж (Словарь иностранных слов, 1988, р. 541).

(“Фрейдизм гэж соёлын үзэгдэл ба нийгмийн амьдрал, хүмүүсийн зан явдалыг амьдралын хүсэл санаанд (ялангуяа хүйсийн) ухамсаргүй илрэн гардаг анхны илрэлийн хэлбэрүүдтэй холбон үздэг, хүмүүсийн ухамсарт үйл ажиллагаа болон амьдралын нийгмийн нөхцөлийн шийдвэрлэх үүргийг тоож үздэггүй сургаал, Австрийн сэтгэлзүйч З. Фрейдийн (1856-1939) нэрнээс ирэлтэй” гэх – коммунист сурталын үнэр бүхий тайлбар аж.)

З. Фрейдийн бичсэнээр бол «Более того, эти же сексуальные влечения участвуют в создании высших культурных, художественных и социальных ценностей человеческого духа, и их вклад нельзя недооценивать» (Фрейд З., 1989, р. 12) гэнэ.

(“Хүний сэтгэлийн эрхэм дээд соёл, уран сайхны болон нийгмийн үнэт зүйлсийг бүтээхэд эдгээр хүйсийн бодол санаанууд оролцдог, тийм болохоор тэдгээрийн хувь нэмэрийг дутуу үнэлж болохгүй” гэнэ.)

З. Фред, хэлшинжлэлч Г. Шперберээс (1912) эш татсан нь: «сексуальные потребности принимали самое непосредственное участие в возникновении и дальнейшем развитии языка. Начальные звуки речи служили сообщению и подзывали сексуального партнера; дальнейшее развитие корней слов сопровождало трудовые операции первобытного человека.... При этом сексуальный интерес переносился на работу. Одновременно первобытный человек делал труд приятным для себя, принимая его за эквивалент и замену половой деятельности. Таким образом, произносимое при общей работе слово имело два значения, обозначая как половой акт, так и приравненную к нему трудовую деятельность. Со временем слово освободилось от сексуального значения и зафиксировалось на этой работе. Следующие поколения поступали точно так же с новым словом, которое имело сексуальное значение и применялось к новому виду труда. Таким образом, возникало какое-то число корней слов, которые все были сексуального происхождения, а затем лишились своего сексуального значения.» (Фрейд З., 1989, р. 104).

(Хэл үүсэн буй болж цаашид хөгжих явц нь хүйсийн хэрэгцээ шаардалгын бүүр шууд оролцоотойгоор болсон. Үг хэлний эхний авианууд нь мэдээлэл өгч хүйсийн хоршилд өдөөн дуудаж байсан. Үгсийн язгууруудын цаашдын хөгжил нь анхны хүмүүсийн хөдөлмөрийн үйл ажиллагааг дагалдаж болсон. ... Тэгэхдээ хүйсийн сонирхол нь ажил хөдөлмөрт шилжих, ажил хөдөлмөрийг хүйсийн үйл ажиллагааны ор, дүйцэл болгон бодох маягаар хүйнэгдлийн хүмүүс ажлыг өөрсдөдөө таатай юм болгож байсан.

Тийнхүү, нийтийн ажил хөдөлмөрийн явцад гарсан үгс нь нэг талаас хүйсийн үйлдэл, нөгөө талаас түүний адилтгал болсон хөдөлмөрийн үйл ажиллагаа – ийм хоёр утгатай байсан. Ингээд цаашдаа тэр үг, хүйсийн утгаа гээж, ажил явдлын утгат үг болон

тогтсон. Хүний дараа дараагийн үеийнхэн яг л энэ мэтээр хүйсийн утга санаа бүхий шинэ үгтэй болж түүнийг ажил хөдөлмөрийн шинэ зүйлд хэрэглэх мэтчилэн хөгжсөн. Иймэрхүү байдлаар, хүйсийн үүсгэл бүхий үгсийн язгуурын нөөц буй болж хожим нь тэр хүйсийн утга санаагаагаа гээдэг ажээ.”)

Энэ үзэл санааны тодорхой жишээнүүд бол миний энэ өгүүлэлд гарсан соёлын үгс байна. Эргэлзээтэй, сэжигтэй юм биш шиг байна.

Би энэ өгүүлэлд монгол хэлтэний шүтээн үгсийн тухай сэдэвийг хөндсөн болохоор мөн энэ чиглэлийн дагуу цааш хэдэн үгийг үзүүлэхийг хүснэ. Нүүдэлчидийн соёлд нутаг хангай (байгаль) чухал. Нутаг хангай дотороо уул нуруу чухал болохоор монголчуудын түүх-соёлын язгуур болсон дөрвөн их ээж (эх этүгэн) уулын нэрийн гаралын талаар санаагаа хэлж өгүүлэл үүнийг төгсгөө.

–**Алтай, Алтай Хан, Арван гурван Алтай** Энэ үгийн анхдагч утгыг одоо хүртэл хадгалж байгаа үндэс нь Cl.Mo. *ala* > Kh. *al* ‘joint of the thighs, groin, crotch; pubicregion; genitals’⁵¹ (Lessing F.D., 1960, p.26).

Эрт сөнөсөн метафор утга нь шүтээн ээж, түүний жишээ: *Alan Eke* (Алан Эх, МНТ §76), *Alan Goya** (Алан Гоо, МНТ §78,10,17, 18,20,22,23). Гарал нэгтэй үгс нь:

а) Kh.: *алцаа* ‘crotch of legs, scissors’, *алцай-* ‘for the legs to be spread apart’, *алха-* ‘to step, walk’, *алавхий-* ‘to jump onto a horse’, *алга* ‘palm of a hand’, *алдар* ‘fame, renown, reputation, popularity’, *алам* ‘hole, crevice, or crack in the earth’, *алба(н)* ‘compulsion, coercion’, *алда-* ‘to lose; to let go, drop; to lose control of’, *ала-* ‘to kill, murder; to butcher’.

б)⁵² Kh. *хала-* ‘to be[come] or feel warm or hot’, ММо. *qala’un/qalayun* ‘эхийн (хүйс) эрхтэн, эхийн умай’⁵³, Kh. *халда-* ‘to touch; to approach, come near; to attack, encroach, to invade, intrude, violate, abuse’, Ммо. *Qaldun, Qaldun-burqan, Burqan-qaldun* (шүтээн уулын нэр, МНТ § 103), Kh. *халдага* ‘penis’.

–**Хангай, Хангай Хан, Хорин дөрвөн Хангай** Үгийн гаралыг заагч үндэс нь Cl.M. *qan-*, Kh. *хана-* ‘to content oneself, be content, satisfied; to be satiated, be full’; ‘to satisfy, fulfill; to provide, supply with’. Энэ үйл үгийн үйлдүүлэх хэв: *qangya-* / *ханга-* ‘to satisfy, fulfill; to provide, supply with’. *Хана-* ба *ханга-* хоёр үйл үг, ардын хэлэнд хүйсийн “дэр нэгтгэх” харилцаанд *orgasmus* –ын утгаар хэрэглэгдэнэ. Тэр тухай ил хэлэх нь “бүдүүлэг” тул тольд: “*ханах – эгээрэл хүслийг хүрэлцэтэл, дүүртэл олох, эдлэх; сэтгэл ханах, хүсэл ханах*” (Цэвэл Я.,1966, р. 657) гэж битүү тайлбар өгчээ. Хангай уулын нэрийн утгыг “*хүсэл бүхнийг хангагч*” (Б. Владимирцов, Б. Ринчен) гэж тайлбарласан нь бий. Гарал нэгтэй үгс нь: Kh.: *ханал* ‘satisfaction, contentment, satiety’,

⁵¹ Халх аялгуунд *ал* гэдэг үг, ихэнхдээ эм бэлгийн нэр байдаг. Толиудад эм гэсэн заалт байхгүйгээс үзвэл зарим газар бас эр бэлгийн нэр бололтой.

⁵² Энэ хэсэг жишээ бол эгшигээр эхлэгч олон үгийн өмнө, өвөг монгол хэлнээ **p* > *q/k* байсан гэх “алтай” хэлний үзэл баримтлалын (үзэмүү: Төмөртоого Д., 1992, р. 153-154) гэрч болсон үгс юм. *Ал* гэдэг үгийг эрт нэг цагт *qala ~ bala* гэдэг байсан бололтой. Халх эмэгтэйчүүдийн уулгамчлах [to utter or shout vulgar words involuntarily; to imitate others’ words or acts involuntarily (affected by jumping disease)] (Lessing F.D., 1966, p.890) хэллэгэнд *халдага балдага* ‘penis’ гэсэн хоршоо үг одоо ч байдаг.

⁵³ МНТ-ны §78 ба §260-д гарсан энэ үгийг хятад хадмал орчуулгад ингэж тайлбарлажээ (үзэмүү: Gadamba S., 1990, р. 271, тайлбар 264).

ханд 'decoction, extract, infusion, sirup, jelly, jam', хан⁵⁴ 'khan, king, chief', хандгай 'elk', ханхай 'large, spacious; empty', ханхай- 'to spread out, expand, to be empty or unoccupied', хань 'friend; companion, partner; husband, wife', ханал 'greed, covetousness, strong desire, passion'.

- **Хөгнө Хан** Хорин дөрвөн Хангай гэдгийн нэг нь, эртний шүтээн уул (төв монгол). Нэрийн гарлын домог тайлбар нь: Ойродын Галдан Бошигт⁵⁵ гэх хан, цэрэглэн ирж энд байсан хийдийн лам нарыг хөгнөж алсан болохоор энэ уулыг *Хөгнө Хан* гэдэг болсон гэнэ (*хөгнө* – rope with ends attached to astake driven in the ground to which lambs and kids are tied; rope to tie the neck of a sheep during milking; *хөгнөд хөгнө-* – to tie a lamb). Миний үзэж байгаагаар бол *хөгнө* гэдэг үгийн гарал нь э. мо. *kökün*, ха. *хөх(өн)* 'female breast, nipples; udder' гэсэн үгнээс ирсэн. Анх эртний нэр нь *ариун сүүгээр хангагч ээжийн мээм уул* (амны хэшигийг хангагч уул) гэсэн санаатай байсан болов уу.

- **Хэнтэй / Хэнтий, Хэнтэй Хан** Үгийн гарал: өвөг монгол хэлний *Kekin /Keken* гэдэг үгний эхэний *Ke* сугарч хаягдасан, эсвэл дундхи *k* суларч, улмаар сугаран гээгдэх явцын үр дүн болно. Эртний метафор утга нь *ээжтэй* уул. Үгийн гарал ба утгын тайлбар, гарал нэгт үгсийг 3.1, 3.2 . хэсэгт үзэмүү.

- **Хинган / Хянган, Хянган даваа** Үгийн гарал: өвөг монгол хэлний **Kekin* гэдэг үгний эхний *k* гийгүүлэгч сугарсаны үр дүн бололтой. Үлгэрлэвэл: **Kekin qan > hekin qan > ekin qan > kin qan > kingyan*. Эртний метафор утга нь *ээж хан* (хүссэн бүхнийг хангагч ээж) уул. Үгийн гарал ба утгын тайлбар, гарал нэгт үгсийн тухайд 3.1, 3.2 хэсэгт үзэмүү. Жич, *Хинган* гэдэг үгний *ган* гэсэн хэсэг бол өвөг хэлний *qan-* (*Хангай* гэдэг үгний гаралыг үзэмүү) гэсэн үйл үгнээс (бас адил утгатай "*qan*" нэр үг байсан байж таарна) ирэлтэй шиг байна. *Хан (qan)* гэсэн энэ үг, монголчуудын суусан нутагийн өдий төдий уулсын нэрэнд эсвэл хойно нь дагаж, эсвэл өмнө нь зүүгдэж явдаг түүхэт үг юм.

Эш авсан ном хэвлэл

ACADEMICÝ SLOVNÍK.CIZÍCH SLOV, ACADEMIA PRAHA, 2001

CLEAVES F.W., 1982, *The Secret History of the Mongols*, For the First Time Done into English out of the Original Tongue and Provided with an Exegetical Commentary, Volume I (translation), Published for the Harvard – Yenching Institute by Harvard University Press Cambridge, Massachusetts London, England, ISBN 0 – 674 – 79670 -5, 277 pp.

ČERINGSODNAM D., 1993, *Mongᠣl-un Niᠷuᠴa Tobčiyan-u orčiᠶulγ-a tayilburi*, Begejing, 545 pp.

DAMDINSÜRÜNG ČE., 1959, *Mongᠣl-un uran jokiyaᠯ-un degeji JAᠭUN BILIG orusibai*, Ulaᠭanbayatur qota, 599 pp.

⁵⁴ *Хан (qan)* 'khan, king, chief' гэдэг үгийн гаралыг хятад хэлнээс ирэлтэй гэж үзэх явдал байдаг. Гэтэл энэ үг, монголын газар усны нэр, онгод сахиусны нэрэнд эзэгнэсэн нь бүр, эхийн эрхэт ёсны үед хамаарна (үзэмүү: *Galayiqan eke, Qan ᠶajar usun, Burγutu qan, Ee qayiraqan: Dulm-a S.*, 1999, p.56, 76, 191)

⁵⁵ Галдан Бошигт – 17 зуунд V Далай ламын засагийн газарын бодолгын дагуу цэрэглэн ирж монголын улаан ламаизмыг устгасан баруун монголын ойрад хан.

- DULM-A, S., 1999, *Mongyol domoy jüi-yin düri*, Bükü ulus-un degedü suryayuli-yin lablaqu materiial, Öbür Mongyol, 295 pp.
- EVEN, M.-D., 1988-1989, *Chants de chamanes mongols*, cahier 19-20, 1988-1989, Paris, 429 pp.
- EVEN, M.-D., POP, R., 1994, *Histoire secrète des Mongols*, Gallimard, UNESCO, Paris, 350 pp.
- ГАДАМБА, Ш., 1990, *Mongyol-un Niyüča Tobčiyān*, Ulayan-bayatur, 421 pp.
- HAENISCH, E., 1948, *Die Geheime Geschichte der Mongolen*. Leipzig, 196 pp.
- LESSING F.D., 1960, *Mongolian-English Dictionary*, Berkeley and Los Angeles, 1217 pp.
- LU.ALTAN TOBČI, 1990, *Altan tobči* - "The Golden Summary which relates briefly the deeds of civil governing established by ancient emperors" (The Mongol chronicle of the 17th century). Ulayanbayatur, 177 pp.
- LUVSANDORDŽ, DŽ., VACEK, J., 1990, *Otázky a odpovědi* (Texty pro rozvíjení dialogu v mongolštině), Praha.
- LUBSANGDORJI, J., 2006, *The Secret History of the Mongols in the mirror of metaphors*. In: *Mongolica Pragensia '06*, Ethnolinguistics and Sociolinguistics in Synchrony and Diachrony. Edited by Jaroslav Vacek and Alena Oberfalzerová. Triton, Praha, pp. 141-161.
- LUBSANGDORJI, J., 2007, *The Secret History of the Mongols in the mirror of metaphors* (2). In: *Mongolica Pragensia '07 sive Folia linguarum Orientis selecta (FLOS)*. Ethnolinguistics, Sociolinguistics and Culture, Volume 1. Charles University in Prague, ISSN 1802-7989, pp. 55-85.
- LUBSANGDORJI, J., 2008, *Diacritic marks in the Mongolian script and the 'darkness of confusion of letters'*. In: *MONGOLO-TIBETICA PRAGENSIA '08*, 1/1, pp. 45-98, Prague.
- NORJIN, C., 1999, *Mongyol kelen-ü toli*, Čiyulultu qayaly-a qota, 3142 pp.
- OBERFALZEROVÁ A., 2008, *Fear and contentment as experienced by the Mongolian nomads. Nutag*, in *MONGOLO-TIBETICA PRAGENSIA '08*, 1/1, pp. 9-43, Prague.
- POPPE N., 1957, *The Mongolian Monuments in HP'AGS-PA SCRIPT*, Otto Harrassowitz – Wiesbaden.
- POPPE N., 1999, *Ancient Mongolian*, in: *ЭРТНИЙ МОНГОЛ ХЭЛНИЙ СҮДЛЭЛ*, (Монголын судлалын сонгомол өгүүлэлийн эрхи – I хэлмэли, II дэвтэр, Улаанбаатар, 126 pp.)
- POUCHA P., 1955, *Tajná Kronika Mongolů*, Praha, 279 pp.
- QORIN NIGETÜ, 1979, *Qorin nigetü tayilburi toli*, Öbür mongyol-un mongyol kele udq-a jokiyal teüke sudulqu yajar emkilebe, Kökeqota, 853 pp.
- RACHEWILTZ, I.-D., 1972, *Index To The Secret History of the Mongols*, Bloomington, 347 pp.
- SUMYABAATAR B., 1990, *The Secret History of the Mongols*, Transcription, Ulaanbaatar, 965 pp.
- TABUN KELEN-Ü TOLI, 1957, *Tabun jüil-ün üsüg-iyer qabsuraysan manju ügen-ü toli bičig*, Begejin, T. I, II, III, 4673 + 71 pp.
- URGUNG EONON, 1993, *CHINGGIS KHAN The Golden History of the Mongols*, London, 188 pp.
- VANGJIL B., 1987, *Köke tülkigür*, Erten-ü üges-ün tayilburi toli, Kökeqota, 696 pp.
- ZIKMUNDOVÁ V., 2008, *Walking on the edges of swords: Notes on analogies in shaman rituals of the Khorchin Mongols and the Jungarian Sibes*, in: *MONGOLICA-TIBETICA PRAGENSIA '08*, 1/2, pp. 149-188.


- БМРС., 2001, *Большой Академический Монгольско-русский Словарь* в четырех томах, Academia, Москва.)
- ВЛАДИМИРЦОВ Б.Я., 1989, *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*, издание 2-е, 437 pp.
- ВЛАДИМИРЦОВ Б.Я., 2005, По поводу древнетюркского *Ötüken üiž*, РАБОТЫ ПО МОНГОЛЬСКОМУ ЯЗЫКОЗНАНИЮ, р. 841 – 844, Москва.
- ГААДАМБА Ш., 1976, *Нууц товчооны нууцаас*, Улаанбаатар, 171 pp.
- ГААДАМБА Ш., ЦЭРЭНСОДНОМ Д., 1978, *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*, Улаанбаатар, 303 pp.
- ДОРЖИ БАНЗАРОВ, 1955, *СОБРАНИЕ СОЧИНЕНИЙ*, 348 pp., Москва.
- ЖАНЧИВ Ё., 2002, *Дөрвөлжин үсгийн монгол дурсгал* (эх, галиг, хөрвүүлгэ, үгсийн хэлхээ, номзүй), Улаанбаатар, 195 pp.
- КОЗИН С.А., 1941, *Сокровенное Сказание Монголов*, введение в изучение памятника, перевод, тексты, глоссарии, М-Л., 619 pp.
- ЛУВСАНДЭНДЭВ А., 1957, *Монгол орос толь*, Москва, 715 pp.
- НАДЕЛЯЕВ В. М. и др. 1969, *Древнетюркский словарь*, Ленинград, 676 pp.
- НЯМБУУ Х., 1992, *Хүндлэхийн дээд Хөх Монголын төрийн ёсон*, Өндөрхаан, 155 pp.
- СЛОВАРЬ ИНОСТРАННЫХ СЛОВ, 1988, Москва, 606 pp.
- ТӨМӨРТОО Д., 1992, *Монгол хэлний түүхэн хэлзүй I* (монгол хэлний түүхэн авиа зүй), Улаанбаатар, 219 pp.
- ФРЕЙД З., 1989, *Введение в психоанализ, лекции*, Москва, “Наука”, 455 pp.; (Freud S., Vorlesungen zur Einführung in die Psychoanalyse Und Neue Folge).
- ЦЭВЭЛ Я., 1966, *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар, 911 pp.
- ЦЭРЭНСОДНОМ Д., 1989, *Монгол ардын домог үлгэр*, Улаанбаатар, 239 pp.

Хураасан үг

- АМо. – Ancient Mongolian (эртний мо.хэл)
- Bur. – Buriat (буриад)
- Cl.Mo. – Classical Mongolian (сонгодог монгол)
- Kalm. Kalmuck (халимаг)
- Kh. – Khalkha (халх, одоогийн монгол хэл)
- Ld. – Лувсандорж (зохиогч)
- Ma. – Manchu (Манж)
- ММо. – Middle Mongolian (дунд үеийн монгол хэл)
- Mu. – Muqaddimat al-adab
- Oir. – Oirat (ойрад)
- Scr.Mo. – Script (Written) Mongolian (монгол бичиг)
- Араб-Ф. – (Арабский филолог)
- Баит – (Баитский говор)
- Захач – (Захачинский говор)
- МНТ – Монголын Нууц Товчоо


Дагалт зураг – 1.

Хорчин монгол нутгийн бөө
Муунохой гуайн Хатан буумал
хэмээх Венера бурхан.



Дагалт зураг – 2.

Словакийн Мораван-над Вагом
нутгийн Венера. Одоогоос хорин
дөрвөн мянган жилийн өмнөх
бурхан гэх.



SUMMARY

This paper is a continuation of the author's research series called 'The Secret History of the Mongols in the mirror of metaphors'. Field research team of the Seminar of Mongolian Studies at Charles University Prague has found the figure of Goddess Venus, which is 20-24 thousand years old, from Horchin Mongolia. Its name might be Etugen in old Mongolian. Based on this, we are trying to explain the historical and cultural words like **эх, этүгэн, нутаг** (The Secret History of the Mongols) and their origins, metaphors and cultural meanings. Some complicated words and expressions like *ötökü yeke qan* - §189, *ötöküs kebtegül* - §230, *ötög uysan-u qoina* - §154, *erkin egede* - §154, *egenegče qoimar* - §165 have been explained differently in this paper.